

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**
/2017 оны хагас жилийн байдлаар/

Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго

Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, УИХ болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлвэрийн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан тогтоол, шийдвэр зүйл, заалтуудын биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.


Хоёр. Арга зүй, ашигласан эх сурвалж

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг 2017 оны хагас жилийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Эрх зүйн актын биелэлтийн хувийг тогтоохдоо Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон ашигласан болно.


Эрх зүйн актын зүйл, заалтын агуулга жил бүр давтагдах шинж чанартай бол тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаагийн үйлчлэлтэй бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр тооцож гаргалаа. Мөн шийдвэр гарсны дараа ямар нэгэн үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байхад тухайн эрх зүйн акт хүчингүй болсон бол үнэлгээ хийхгүй үлдээж ерөнхий үнэлгээ гаргах зүйл заалтын тооноос хасаж тооцсон болно.

Гурав. Үнэлгээний дүн

3.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2017 оны эхний хагас жилийн байдлаар ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан ёсны цахим хуудсанд байршуулсан нийт 75 тогтоол, шийдвэрийн 120 заалтаас ХХААХҮЯ-ны үндсэн чиг үүрэгт хамаатай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Улсын Их Хурал, УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл нийлсэн нийт 75 тогтоол, шийдвэрийн 120 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийсэн.



Дээрх заалтуудын 30 (25 хувь) нь бүрэн биелэгдсэн, 36 (30 хувь) заалт хэрэгжилтийн шатанд, 34 (25.3 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй, 15 (12.5 хувь) заалт хэрэгжээгүй байгаа ба биелэлтийн дүн дунджаар **56.9** хувьтай үнэлэгдэв. Хугацаа болоогүй 4 заалт, ХХААХҮ-ийн эрхлэх асуудлын үндсэн чиг үүрэгт хамааралгүй 1 заалт байна.



Монгол Улсын Хуулийн хяналтад авсан 9 зүйл заалтын 20 заалт хяналтанд авсны 1 (100хувь) заалт бүрэн хэрэгжсэн, 3 (70 хувь) заалт хэрэгжих шатанд, 10 (30 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй, 5 (0 хувь) заалт хэрэгжээгүй, 1 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэв.

Улсын Их Хурлын тогтоолын хяналтад авсан 7 зүйл заалтын 11 заалт хяналтанд авсны 3 (100хувь) заалт бүрэн хэрэгжсэн, 3 (70 хувь) заалт хэрэгжих шатанд, 4 (30 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй, 1 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэв.

Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоолын хяналтад авсан 3 зүйл заалтын 8 заалт хяналтанд авсны 3 (100хувь) заалт бүрэн хэрэгжсэн, 4 (70 хувь) заалт хэрэгжих шатанд, 1 заалт дүгнэгдээгүйгээр тус тус үнэлэгдэв.

Ерөнхийлөгчийн зарлигийн хяналтад авсан 3 зүйл заалтын 9 заалт хяналтанд авсны 3 (100хувь) заалт бүрэн хэрэгжсэн, 1 (70 хувь) заалт хэрэгжих шатанд, 3 (30 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй, 1 (0 хувь) заалт хэрэгжээгүй, 1 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэв.

Засгийн газрын тогтоолын хяналтад авсан 25 зүйл заалтын 31 заалт хяналтанд авсны 11 (100хувь) заалт бүрэн хэрэгжсэн, 9 (70 хувь) заалт хэрэгжих шатанд, 10 (30 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй, 1 (0 хувь) заалт хэрэгжээгүйгээр тус тус үнэлэгдэв.


Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хяналтад авсан 26 зүйл заалтын 34 заалт хяналтанд авсны 10 (100хувь) заалт бүрэн хэрэгжсэн, 13 (70 хувь) заалт хэрэгжих шатанд, 6 (30 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй, 4 (0 хувь) заалт хэрэгжээгүй, 1 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэв.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж хяналтад авсан 2 зүйл заалтын 7 заалт хяналтанд авсны 3 (70 хувь) заалт хэрэгжих шатанд, 2 (30 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй, 2 (0 хувь) заалт хэрэгжээгүйгээр тус тус үнэлэгдэв.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудаас бүрэн хэрэгжсэн болон хугацаа нь дууссан, цаг үеийн асуудлаар гарч зохих үр дүнд хүрсэн 6 шийдвэрийн 7 заалтыг хасуулах саналтай байна. Саналын үндэслэл нь тогтоол, шийдвэрийн зарим заалт бүрэн хэрэгжсэн, мөн хүчингүй болсон, хугацааны хувьд ач холбогдолгүй, төсөв нь татагдсан, хөрөнгө оруулалт байхгүй зэрэг болно.

Дөрөв. Дүгнэлт

4.1. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, УИХ болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтын 27.5 хувь нь 2014 оноос өмнө, 12.5 хувь нь 2015 онд, 60 хувь нь 2016 оноос хойш шинээр батлагдсан байна.



4.2. Хэд хэдэн салбар хамтран хэрэгжүүлэхээр заасан эрх зүйн актын хэрэгжилт хангалтгүй байх тохиолдол гарч байна. Тухайлбал:

- “Эрүүл ахуйн тухай” хуулийн 4.4.2-т заасан хог хаягдлын жагсаалт, булшлах, устгах аргачлалыг эрүүл мэнд болон хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэсэн заалтын хэрэгжилт “0” үнэлгээтэй байна.
- Монгол Улсын ерөнхийлөгчийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх” тухай 158 дугаар зарлигийн 1.4 дахь ... Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээр ашиглах уламжлалт арга ажиллагааны дэвшилтэт хэлбэрийг хэрэгжүүлж, хөрс бэлчээр сайжруулах дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх ... гэсэн заалтын хэрэгжилт “0” үнэлгээтэй, тодорхой үр дүнтэй ажил хийгдээгүй байна.

Тав. Зөвлөмж

- 5.1. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.6-д “... Бодлогын зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хоёр удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол удааширсан, гурван удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол тасарсанд тооцно ...” гэж заасныг баримтлан Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.2 дахь заалт, Тариалангийн тухай хуулийн 15.7, 15.8 дахь хэсэг, мөн түүнчлэн “Засгийн газарт чиглэл өгөх” тухай Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигийн 1.2 болон 1.4 дэх заалтуудын хэрэгжилт тус тус удааширсан тул, эдгээр арга хэмжээнүүдэд онцгой анхаарал хандуулан хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.
- 5.2. Түүнчлэн Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан хяналт-шинжилгээ үнэлгээний шинэчилсэн журмаар үнэлгээний арга өөрчлөгдөж, үнэлгээг хэрэгжсэн эсвэл хэрэгжээгүй гэсэн шалгууруудад хуваан үр дүнд анхаарах болсонтой холбогдуулан хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй буюу “30 хувь”, хэрэгжээгүй, бэлтгэл хангах ажил хийгдэж байгаа, мөн боловсруулалтын шатанд байгаа буюу “0 хувь” үнэлгээтэй ажлуудын биелэлтийг холбогдох газрууд болон харьяа байгууллагууд зохион байгуулалтын арга хэмжээ авч, жилийн эцсээр биелэлтийг сайжруулан ажиллах шаардлагатай байна.
- 5.3. Хэрэгжилтийн тайлан хангалтгүй эсвэл тодорхой ажил хийгдээгүйгээс тухайн заалтад хамааралгүй биелэлт гаргасан, хэрэгжилтийн талаархи мэдээлэл нь үйл ажиллагаа /процесс/ тайлагнасан алдаа дутагдал гарч байгааг анхаарч тайланд ажлын гол үр дүнг оруулж байхыг зөвлөмж болгож байна.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЛБАРТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

2017 оны хагас жилийн байдлаар. /Хүснэгт-1/

	Бүгд	Үүнээс									
		Монгол улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл
Хяналтанд авсан тогтоол шийдвэрийн тоо	75	9	7	3	3	25	26	-	-	2	-
Хяналтанд авсан нийт зүйл заалтын тоо	120	20	11	8	9	31	34	-	-	7	-
Үүнээс	Биелсэн 100.0%	30	1	3	3	3	11	10	-	-	-
	Хэрэгжих шатанд:	36	3	3	4	1	9	13	-	-	3
	Хэрэгжилт хангалтгүй	34	10	4	-	3	10	6	-	-	2
	Хэрэгжээгүй	15	5	-	-	1	1	4	-	-	2
	Хугацаа болоогүй	4	1	1	-	1	-	1	-	-	-
	Дүгнэгдээгүй	1	-	-	1	-	-	-	-	-	-

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ (шийдвэр, заалтаар)**

2017 оны хагас жилийн байдлаар. /Хүснэгт-2/

№	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	д/д	Зүйл, заалтын дугаар	Биелүүлэх хугацаа, оноор	Хэрэгжилтийн явц, хувиар
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ						
1	2010	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай	1	22.6	2010	100
2	2012	Зээлийн батлан даалтын сангийн тухай	2	11.2.	2012	30
			3	13.4.		30
3	2012	Агаарын тухай хууль	4	21.4	2012	30
4	2012	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	5	7.2	2012	30
			6	9.5	2012	0
			7	14.1.	2012	70
5	2012	Хүнсний тухай	8	6.2	2012	0
			9	16.2.	2012	30
6	2015	Хөгжлийн төлөвлөлтийн тухай бодлого	10	7.5	2017	ХБ
7	2016	Тариалангийн тухай	11	15.7	2016	0
			12	15.8.	2016	0
			13	19.6.	2016	70
			14	23.4	2016	70
			15	24.5.	2016	30

8	2016	Эрүүл ахуйн тухай	16	4.5.	2016	0
9	2016	Органик хүнсний тухай	17	8.3	2016	30
			18	8.4	2016	30
			19	10.3	2016	30
			20	11.6	2016	30
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ						
1	2009	№39	1	2.2	2009	30
2	2012	№74	2	2.1	2012	30
			3	2.4	2012	30
3	2015	№ 52	4	5.2.2	2015	100
4	2015	№ 62	5	2.1.	2015	30
			6	2.2	2015	100
			7	2.3.	2015	70
			8	2.4.	2017	ХБ
5	2015	№: 108	9	3	2015	70
6	2016	№: 19	10	2	2016	100
7	2016	№46	11	2	2016	70
УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ						
1	2012	№ 02	1	1.1.	2012-	70
			2	1.2.	2012-	70
			3	1.3.	2012-	70
			4	2.1.	2012-	70
			5	2.2.	2012-	100
2	2015	№07	6	2	2015	Хам
3	2016	№03	7	11	2016	100
			8	14	2016	100
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ						
1	2007	№:97	1	2	2007	70
2	2013	№ 88	2	1	2013	100
			3	2	2013	100
3	2016	№158	4	1.2	2016	30
			5	1.3	2016	30
			6	1.4	2016	0
			7	1.5	2017	30
			8	1.6	2016	100
			9	3	2017	ХБ
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ						
1	2009	№ 208	1	3	2009	30
2	2010	№ 222	2	3	2010	70
3	2012	№ 158	3	2	2012	70
4	2013	№ 366	4	3	2013	70
5	2015	№ 286	5	3	2015	70
6	2015	№ 325	6	3	2015	70
7	2015	№353	7	2	2015	70
8	2016	№37	8	2	2016	30
9	2016	№:197	9	2	2016	100
10	2016	№240	10	5	2016	100

			11	6	2016	70
11	2016	№241	12	2	2016	100
12	2016	№287	13	2	2016	30
			14	4	2016	30
13	2016	№90	15	2	2016	30
14	2016	№121	16	3	2016	30
15	2016	№138	17	2	2016	70
16	2016	№187	18	1	2016	30
			19	2	2016	100
17	2016	№193	20	6	2016	100
18	2017	№6	21	4	2017	100
19	2017	№14	22	1	2017	100
			23	2	2017	100
20	2017	№27	24	3	2017	70
			25	4	2017	100
21	2017	№41	26	3	2017	100
22	2017	№46	27	1	2017	30
			28	2	2017	30
23	2017	№98	29	3	2017	0
24	2017	№111	30	2	2017	100
25	2017	№150	31	2	2017	30
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ						
1	2014	59 дүгээр тэмдэглэл	1	II.2.	2014	70
2	2014	63 дугаар тэмдэглэл	2	IX.3.	2014	100
3	2015	1 дүгээр тэмдэглэл	3	XII.4	2015	70
4	2015	05 дугаар тэмдэглэл	4	XIV.2.	2015	0
5	2015	33 дугаар тэмдэглэл	5	III.	2015	100
6	2015	43 дугаар тэмдэглэл	6	XXY.1.	2015	100
7	2016	11 дүгээр тэмдэглэл	7	XIV.	2016	70
8	2016	18 дугаар тэмдэглэл	8	XIX.3.	2017	ХБ
9	2016	20 дугаар тэмдэглэл	9	XXIII.2.	2016	100
10	2016	25 дугаар тэмдэглэл	10	XVI.	2016	70
11	2016	29 дүгээр тэмдэглэл	11	XVII.	2016	0
12	2016	39 дүгээр тэмдэглэл	12	XI.1.4	2016	70
13	2016	43 дугаар тэмдэглэл	13	IX.3.1	2016	100
			14	IX.3.3	2016	30
15	2016	48 дугаар тэмдэглэл	15	X.	2016	100
			16	XVII.2.1	2016	70
			17	XVII.2.2	2016	30
			18	XVII.2.5	2016	70
			19	XVII.2.6.	2016	100
16	2016	49 дүгээр тэмдэглэл	20	XIV.4.3	2016	70
17	2016	52 дугаар тэмдэглэл	21	XIII.1.2	2016	70
18	2016	55 дугаар тэмдэглэл	22	XXYI.5.4	2016	70
			23	XXYI.6.1	2016	100
			24	XXYI.6.2	2016	70
19	2016	57 дугаар тэмдэглэл	25	1	2016	100

20	2016	58 дугаар тэмдэглэл	26	ХП.2.2	2016	30
21	2016	60 дугаар тэмдэглэл	27	XIV.2	2016	70
			28	ХХҮШ.7.	2016	30
22	2017	1 дүгээр тэмдэглэл	29	ҮП. 3.	2017	100
23	2017	6 дугаар тэмдэглэл	30	ХП.2.	2017	30
24	2017	13 дугаар тэмдэглэл	31	ҮП.2.	2017	0
			32	ХҮЛ.1.	2017	70
25	2017	14 дүгээр тэмдэглэл	33	ГҮ.2.	2017	0
26	2017	19 дүгээр тэмдэглэл	34	П.	2017	30
ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ						
1	2011	23/20	1	1	2011	30
			2	3	2011	0
			3	4	2011	70
			4	5	2011	70
			5	6	2011	30
2	2012	19/12	6	3	2012	70
			7	5	2012	0

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛ ОРУУЛЖ БУЙ ЗААЛТУУДЫН ТОВЧОО

/Хүснэгт-3/

Д/д	Эрх зүйн баримт бичиг	Шийдвэрийн тоо	Зүйл заалтын тоо
1	Монгол Улсын хууль	1	1
2	Улсын их хурлын тогтоол	1	1
3	УИХ-ын БХ-ны тогтоол	1	2
4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	3	3
Нийт		6	7

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛ ОРУУЛЖ БУЙ ЗААЛТУУДЫН АГУУЛГА

/Хүснэгт-4/

д/д	Шийдвэрийн Он, сар, өдөр	д/д	Зүйл заалтын агуулга	Хяналтаас хасуулах шалтгаан	Үнэлгээ
1	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай 2010.05.27	1	22.6 Улсын бүртгэлд эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн бүртгэх, түргэвчилсэн журмаар бүртгэх, хугацаа, бүртгэлийн төлбөр тогтоох, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журам, дүрмүүд батлагдан мөрдөгдөж эхэлсэн тул хяналтаас хасах саналтай	100
2	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	2	Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого,	Хэрэгжсэн тул хяналтаас хасах	100

	батлах тухай 2016-02-05 №: 19		хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах;		
3	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-11-23 №03	3	11. Улсын Их Хурлын 2012 оны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоолын 2.5 дахь заалтад заасны дагуу арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх ажлыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх;	Энэ тогтоол нэг удаагийн чанартай бүрэн хэрэгжсэн тул хасах саналтай байна.	100
		4	14. Тогтоолын биелэлтийн явцыг 2016 оны намрын чуулганы хугацаанд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /Д.Оюунхорол/, Барилга, хот байгуулалтын яам /Г.Мөнхбаяр/, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /Ц.Дашдорж/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /П.Сэргэлэн/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н Цагаанхүү/, нийслэлийн Засаг дарга /С.Батболд/-д тус тус даалгасугай		100
4	2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр 1 дүгээр тэмдэглэл	5	ХП.4 Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар Хууль зүйн сайд Д.Дорлигжав Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав: 4.1. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл боловсруулахдаа эрх, ашиг	Хүчингүй болсон тул хяналтаас хасах	70

			сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийн саналыг авч, шаардлагатай бол саналыг тусгах арга хэмжээ авах; 4.2. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцож байх; 4.3. Шинээр гарсан хууль тогтоомжид нийцүүлэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж байх; 4.4. хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахгүй байх		
5	2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр 20 дугаар тэмдэглэл	6	ХХШ.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны худалдан авах ажиллагааны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнг Сангийн сайд Б.Болор Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хяналтаас хасах	100
6	2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 48 дугаар тэмдэглэл	7	Х. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн үзэл баримтлалын төслийг хэлэлцээд зохих журмын дагуу хянан баталж, хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт нарт даалгав.	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай байна.	100

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/ 2017 оны хагас жилийн байдлаар/ /Хүснэгт-5/

№	Шийдвэрийн нэр,огноо, дугаар	Зүйл, заалтын дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Тайлбар	Үнэлгээ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ					
1	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай 2010.05.27	22.6 Улсын бүртгэлд эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн бүртгэх, түргэвчилсэн журмаар бүртгэх, хугацаа, бүртгэлийн төлбөр тогтоох, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/22 дугаар тушаалаар “Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах дүрэм”, “Малын эмийн улсын бүртгэлийн журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллав. Ажлын хэсэг ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-49 дугаар тушаалаар Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах дүрэм, Улсын бүртгэлд малын эм, эмийн түүхий эд бүртгэх, түргэвчилсэн журмаар бүртгэх, хугацаа төлбөр тогтоох, зарцуулах журмыг батлуулав. Хууль, зүй дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актыг улсын бүртгэлийн 3724 дүгээрт бүртгүүлсэн. Малын эмийн салбар зөвлөлийн хуралдааныг 2017 онд 2 удаа зохион байгуулж улсын бүртгэлд Шинээр 12 нэр төрлийн мал, амьтныг эм, биобэлдмэл бүртгэж, улсын бүртгэлийн хугацаа дууссан 14 нэр төрлийн малын эмийн бүртгэлийн хугацааг сунгав. Мөн антибиотикийн эмийг зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор орон нутгийн сургалтыг 4 аймагт зохион байгуулав.	Журам, дүрмүүд батлагдан мөрдөгдөж эхэлсэн тул хяналтаас хасах саналтай	100
2	Зээлийн батлан даалтын сангийн тухай 2012-02-10	11.2. Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.	Сангийн яам, Зээлийн батлан даалтын сан, ЖДҮХСантай хамтран Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болон давхар батлан даалтын журмыг боловсруулах ажлын хэсэг байгуулан БНСУ-ын KOREG-KED олон улсын байгууллагатай хамтран 3 сарын турш туршлага солилцож батлан даалтын сангийн журмыг боловсруулсан. Зээлийн батлан даалтын сангийн удирдлагуудтай албан ёсоор Давхар батлан даалтын талаар хэлэлцүүлэг хийж журамд дахин санал авах болсон Давхар батлан даалтын журмыг 2015 онд Зээлийн батлан даалтын сангаас боловсруулж ирүүлсэн бөгөөд одоо байгаа нөхцөл байдлын хувьд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь эрсдлийн сангүй тохиолдолд давхар батлан даалт гаргах бололцоогүй байна. Давхар батлан даалт гаргахын тулд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд тусгайлан эрсдлийн сан үүсгэж эх үүсвэр хуваарилах шаардлагатай байна.		30

		<p>13.4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас гаргах давхар батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хөлсийг Сантай зөвшилцөж, жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.</p>	<p>13.4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмын төсөлд давхар батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хөлсийг тогтоох тухай санал оруулах ажлын хэсгийн ЖДҮХС, ЖДҮБЗГ, Батлан даалтын сан, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны бүрэлдэхүүнтэй байгуулан анхны хэлэлцүүлгийг хийсэн. Зээлийн батлан даалтын сангийн удирдлагуудтай албан ёсоор Давхар батлан даалтын талаар хэлэлцүүлэг хийж журамд дахин санал авах болсон.</p> <p>Давхар батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хөлсийг тогтоох талаар ярилцаж эцсийн шийдвэр гараагүй байна. Зээлийн батлан даалтын сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Сангийн яам болон Аж үйлдвэрийн яамны төлөөлөл байдаг. Давхар батлан даалтын журмыг боловсруулж батлуулах ажлыг Сангийн яам давхар хариуцана.</p> <p>Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтийн тухай хэлэлцүүлгийг 2017.03.14 өдөр зохион байгуулав.</p> <p>Хуульд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд гаргаж буй батлан даалтын тодорхой хувийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар давхар батлан даалгуулах өөрчлөлт хийх саналыг тусгахаар хэлэлцүүлэв. Давхар батлан даалтын асуудал шийдэгдээгүй учир шимтгэл, үйлчилгээний хөлс тодорхойгүй байна.</p>		30
3	<p>Агаарын тухай хууль</p> <p>2012-05-17</p>	<p>21.4 Суурин газрын агаар хамгаалах зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хүн амын суурьшлын бүсээс зааглах бөгөөд уг бүсийн хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, төрөл бүрээр тогтоосон жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ХХААХҮ-ийн Сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусган ажиллаж байна.</p>		30
4	<p>Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай</p> <p>2012.12.20</p>	<p>7.2 Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг</p>	<p>Хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг эхний байдлаар боловсруулсан. Зааврын төсөлд хэлэлцүүлэг зохион байгуулж, энэ оны 4 дугаар улиралд батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>		30

		<p>хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална./7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ:7.1.1.хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал;7.1.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал;7.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал.</p>			
		<p>9.5 Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилттэй холбогдуулан хүчингүй болгосон тус журмын төслийг шинэчлэн боловсруулж байна.</p>		0
		<p>14.1. Хувиргасан амьд организаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.</p>	<p>ЭМСЯ, ХХААЯ болон БОАЖНХЯ-ны хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, журмын төслийг боловсруулж 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, ЭМ-ийн сайдаар батлуулахаар хүргүүлсэн. Гэвч Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус журмын төслийг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон тул Журмын төслийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.</p>		70

5	Хүнсний тухай 2012.12.20	6.2 Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална. /6.1: Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ/.	Журмын төслийг 2017 онд боловсруулахаар яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан.		0
		16.2.Энэ хуулийн 16.1-д заасан баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгэх” журмын төслийг ажлын хэсэг боловсруулан, мэргэжлийн хяналтын байцаагчид, хүнс үйлдвэрлэгчдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар төслийг хэлэлцүүлж зөвлөлийн гишүүдийн саналыг тусган дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. 2017 оны 9-р сарын байдлаар журмыг эцэслэн боловсруулан дахин хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.		30
6	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 2015.11.26	7.5 Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	Хугацаа болоогүй.		ХБ
7	Тариалангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-01-29	15.7 Тариалангийн газрыг атаршуулсан, атар газрыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хагалсан бол буруутай этгээд нөхөн сэргээж, хохирлыг барагдуулна.	Энэ хуулийн 15.7-д заасан “газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлал”-ын журмаар зохицуулагдана.		0
		15.8. Энэ хуулийн 15.7-д заасан газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлалыг тариалангийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Энэ хуулийн 15.7-д заасан “газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлал”-ыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А-202 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна.		0

		<p>19.6.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг тариалангийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>	<p>Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсруулж байна. ХХАА-н Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсөвт улаанбуудайн урамшуулал олгохоор тусгаж 610 иргэн аж ахуйн нэгжид 5.6 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна. 2016 оны ургацаас гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн хүнсний буудайнд анх удаа чанарын ангилалаар мөнгөн урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай танилцуулга, тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2017 оны А/62 дугаар тогтоолоор 1 дүгээр ангилалын буудайн тонн тутамд 55.0 мянган төгрөг, 2-4 дүгээр ангилалын буудайн тонн тутамд 50.0 мянган төгрөг олгохоор шийдвэрлүүлснээр нийтдээ 726 аж ахуйн нэгж, иргэний 292.4 мянган тонн хүнсний буудайнд 14.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгов.</p>		70
		<p>23.4. Энэ хуулийн 23.1-д заасан мэдээ гаргах, хүргүүлэх болон энэ хуулийн 23.3-г заасан мэдээллийн сан бүрдүүлэх журмыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Тариалангийн газрын ангилал тус бүрээр болон тариалсан таримал, сорт, үр, техник, хураасан ургацын мэдээг сум, дүүргээр нэгтгэж авахаар 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 05/1270 албан тоот хүргүүлж тайланг нэгтгэн авч байна. 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Төрийн нарийн бичгийн даргын А-142 дугаар тушаалаар байгуулагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх зорилгоор салбарт ашиглагдаж байгаа мэдээллийн сангуудын мэдээллийг нэгтгэх, нэгдсэн санд оруулах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 2017 онд яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан баг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газартай ажлын уулзалт зохион байгуулж Мэдээллийн сангийн журмыг боловсруулах чиглэлээр хамтарсан ажлын хэсэг байгуулахаар тохиролцоонд хүрч, хэрэгжүүлж эхлээд байна.</p>		70
		<p>24.5. Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлалыг тариалангийн, хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>	<p>Аргачлал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А-203 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна.</p>		30

8	Эрүүл ахуйн тухай 2016.02.04	4.5.Энэ хуулийн 4.4.2-т заасан хог хаягдлын жагсаалт, булшлах, устгах аргачлалыг эрүүл мэнд болон хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн яамнаас 2017 онд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнд аргачлалын төслийг боловсруулахаар үүрэг өгсөн болно. -Мал эмнэлгийн салбарт хамаарах асуудлаар тодорхой асуудал зохион байгуулагдаагүй байна.		0
9	Органик хүнсний тухай 2016-04-07	8.3 Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам, хэрэглэх бодисын жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	1. “Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам, хэрэглэх бодисын жагсаалт” нь “Органик газар тариалан эрхлэхэд баримтлах журам”, Мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журам, Органик зөгийн аж ахуйд тавигдах шаардлагууд, Органик бүтээгдэхүүнийг боловсруулахад баримтлах журмын төслүүд болон эдгээр салбарт хэрэглэхийг зөвшөөрөх бодисын жагсаалтаас бүрдэж байгаа бөгөөд нийт 34 хуудас журмын нэгдсэн төслийг боловсруулж, www.mofa.gov.mn цахим хуудаст байршуулан, Захиргааны Ерөнхий хуулийн дагуу Улаанбаатар хотод үйлдвэрлэгч, хэрэглэгч, ТББ, судалгааны шинжилгээ, сургалтын байгууллага, сүлжээ дэлгүүрүүд, СХЗГ, МХЕГ-ын 570 гаруй төлөөлөл оролцсон 19 удаагийн хэлэлцүүлэг, 400 гаруй оролцогч бүхий 20 гаруй хэлэлцүүлгийг 13 аймагт зохион байгуулж, хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг тусгасан болно. Яамны Хуулийн хэлтэс болон ХХААХҮ-ийн Сайдын Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх техникийн саналыг бэлдэж хүргүүлсэн болно. 2. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр “Органик хөдөө аж ахуйн гарын авлага”, “Органик хүнс үйлдвэрлэлд тавигдах шаардлагууд” номыг тус бүр 500 хувь, Органик хүнсний тухай хуулийн англи, монгол хэл дээрх гарын авлага, хуулийн тухай 5 төрлийн зурагт хуудсыг тус бүр 2000 хувийг хэвлүүлж, олон нийтэд түгээв.		30
		8.4 Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлалыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний органик орцын хувь хэмжээг тооцох аргачлалын төслийг АНУ, Канад, Европын Холбоо, Кодекс, ОХААХОУХ зэрэг улс орон, байгууллагын батлан гаргасан стандарт, аргачлалыг судалсны үндсэн дээр боловсруулж, www.mofa.gov.mn цахим хуудаст байршуулан, Захиргааны Ерөнхий хуулийн дагуу давхацсан тоогоор 10 гаруй хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг тусган, Яамны Хуулийн хэлтэс болон ХХААХҮ-ийн Сайдын Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх техникийн саналыг бэлдэж хүргүүлсэн болно.		30
		10.3 Энэ хуулийн 10.1-д заасан баталгаажуулалтын байгууллагыг	БНЭУ, ОХААХОУХ-ны зөвлөмж, журмыг судлан Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах журмын		30

		бүртгэх журмыг үндэсний итгэмжлэлийн байгууллага, 10.2-т зааснаар баталгаажуулах тохиолдолд түүнд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	төслийг боловсруулж, www.mofa.gov.mn цахим хуудаст байршуулан, Захиргааны Ерөнхий хуулийн дагуу давхацсан тоогоор 15 орчимхэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг тусган, Яамны Хуулийн хэлтэс болон ХХААХҮ-ийн Сайдын Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх техникийн саналыг бэлдэж хүргүүлсэн болно.		
		11.6 Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АНУ, БНЭУ, Канад, Европын Холбоо, Кодекс зэрэг улс орон, байгууллагын батлан гаргасан стандарт, зааврыг судалсны үндсэн дээр боловсруулж, www.mofa.gov.mn цахим хуудаст байршуулан, Захиргааны Ерөнхий хуулийн дагуу давхацсан тоогоор 7 орчим хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг тусган, Яамны Хуулийн хэлтэс болон ХХААХҮ-ийн Сайдын Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх техникийн саналыг бэлдэж хүргүүлсэн болно.		30
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ					
1	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого батлах тухай 2009.06.04 №39	2.2 Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилт, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэх.	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилт, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд жил бүр тусган хэрэгжүүлж байна. Үүнд: -Үндэсний үйлдвэрүүдийн түүхий эдийн хангамжийг сайжруулах, малын арьс, шир, ноосны чанарыг дээшлүүлэх зорилгоор 2011-2015 онд 408812 малчинд 71.5 мянган тонн ноосны урамшуулалд 112.7 тэрбум төгрөг, 2013-2015 онд 132431 малчны 5.3 сая арьс, ширний урамшуулалд зориулж 20.3 тэрбум төгрөг олгох ажлыг зохион байгуулсан. -2016 оны ноосны урамшуулалд 22.3 тэрбум, арьс, ширний урамшуулалд 15.7 тэрбум төгрөгийг тус тус олгосон.		30
2	Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2012.12.28 №74	2.1 Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай: гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд	Засгийн газрын 2013 оны 394-р тогтоолоор “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батлуулан мөрдөж байна. 2017 оны төсөвт Засгийн газрын 2017-01-11-ний 14-р тогтоолоор арьс ширний урамшуулалд 10,8 тэрбум төгрөг батлагдсан. 2016 онд нийт 64,255 малчин, мал бүхий этгээдийн тушаасан 3,1 сая арьс, ширэнд 12,7 тэрбум төгрөг олгох ХХААХҮ-ийн Сайдын тушаал гарсан бөгөөд Сангийн яаманд зарцуулалтын эрх нээгдвэл 6-р сард багтаан малчдын дансанд урамшууллын гүйлгээ хийгдэх болно.		30

	<p>3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулал олгох;</p> <p>2.4 энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үйлдвэрлэгчид олгох зээлийн хүүг жилийн 7 хувиас илүүгүй байхаар тооцож олгох;</p>	<p>УИХ-ын 2012-12-28-ны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 -р тогтоол “Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулж 140,4 тэрбум /нэг зуун дөчин тэрбум дөрвөн зуун сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн.</p> <p>ЗГ-ын 2013 оны 48 -р тогтоол “Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах, түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, тайлагнах журам” батлуулсан.</p> <p>ЗГ-ын 2014 оны 198-р тогтоол, 2014 оны 217 -р тогтоолоор “Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төсөлд олгох эх үүсвэрийг нийт 140,4 тэрбум (нэг зуун дөчин тэрбум дөрвөн зуун сая) төгрөгөөр баталж, Хөгжлийн банктай дамжуулан зээлдэх нөхцлийг зөвшөөрч гэрээ байгуулсан арилжааны банкуудаар дамжуулан жилийн 7 хувийн хүүтэй зээл олгохоор тогтсон бөгөөд арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдийн төсөлд 2014 оны 8-р сараас эхэлж, Хөгжлийн банкны санхүүжилтээр 9 арилжааны банкаар дамжуулан нийт 57 үйлдвэрт 86 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. /2016 оны 11 сарын 1-ний байдлаар/ хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосон. Зээл олголтыг / Эх үүсвэрийг өөр зориулалтаар зарцуулсан гэх шалтгаанаар 2016 оны 6-р сараас хойш зээл олгогдоогүй.</p>		30
	<p>2.5. Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах;</p>	<p>УИХ-ын 2012-12-28-ны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 -р тогтоол “Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулж 140,4 тэрбум /нэг зуун дөчин тэрбум дөрвөн зуун сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн.</p> <p>Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх, арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих асуудлаар Турк, Испани, Франц, Израйль, Япон, Голланд, Хятадын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, харьцуулсан судалгаа хийгдсэн.</p>		70

		<p>Мөнтүүнчлэн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутгийн заагт 50 га газарт “Арьс, ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих Техник, эдийн засгийн үндэслэл судалгаа”- г тодотгож, цаашид хийх шаардлагатай ажлуудыг нарийвчилсан төлөвлөгөө гарсан байна. Арьс, ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах байршлыг дахин судалж тогтоох тухай Засгийн газрын 2013-07-06-ны өдрийн 249 дүгээр тогтоол гарсан байна. Тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Дархан-Уул аймагт байгуулах Арьс ширний үйлдвэрлэлийн цогцолборын мастер төлөвлөгөө, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах” ажил тус тус хийгдсэн байна. Энэ ажлыг н үр дүнг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ-ын байнгын хороодод, Ерөнхий сайдад танилцуулж байсан.</p> <p>“Арьс, ширний үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 249 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх явцад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа арьс шир боловсруулах үйлдвэрүүд болон Дархан-Уул аймгийн иргэд Арьс, ширний үйлдвэрлэлийн цогцолборыг Дархан-Уул аймагт байгуулах асуудлыг дэмжихгүй байсан тул Засгийн газрын 2014-03-14-ний өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэл гарч, байршлыг сонгон шалгаруулсны үндсэн дээр дэд бүтэц байгуулах ажлыг эхлүүлэх нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>Түүнчлэн Засгийн газрын 2014-10-11-ний өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэлийн дагуу БОНХСайд, ҮХААСайд нар шинэ суурьшлын бүсийн газрын төлөв байдалтай очиж танилцаад, Засгийн газрын 2014-11-01-ний өдрийн хуралдаанаар “Арьс, ширний үйлдвэрлэлийн цогцолборын байршлын тухай” асуудлыг хэлэлцүүлж, 356 дугаар тогтоол батлагдсан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2016-11-23-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017-12-31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ХХААХҮ-ийн Сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусган ажиллаж байна.</p> <p>Дээрхи үйлдвэрийн бүсийг үйлдвэрлэл технологийн паркийн хэлбэрээр зохион байгуулахаар төслийн бэлтгэл ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:</p> <p>“Аж үйлдвэрлийн парк”-ийн техник эдийн засгийн үндэслэл, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол,</p>		
--	--	--	--	--

			<p>Үерийн байгууламжийн ажлын зураг төсөл, Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл, Технологийн усан хангамжийн ажлын зураг төсөл, Ундны усан хангамжийн ажлын зураг төсөл, Паркийн техник технологийн түвшний үнэлгээ, Паркийн цэвэрлэх байгууламжийн судалгаа зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулсан. Бүтээн байгуулалтын хувьд барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг байгуулаад байна Дээрхи шинэ бүсийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП” ОНӨТҮГ-аас үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн хүсэлт, материалыг судалж үзэхэд тус газрын ирүүлсэн ТЭЗҮ хуучирсан, тодотгол хийсэн материал албажаагүй тул дахин боловсруулах үүрэг өгч буцааж, шинэчилсэн материалыг хүлээн авч Засгийн газрын 2017-06-20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 178-р тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийг олгосон байна.</p>		
3	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай 2015-06-11 № 52	5.2.2/Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад тавих дотоодын байнгын хяналтыг сайжруулах, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх Засгийн газрын байгууллагын чадавхыг сайжруулах арга хэмжээ авах	Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад тавих дотоодын байнгын хяналтыг сайжруулж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ эхний хагас жилийн байдлаар хийж, дүнг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/1917 тоот албан бичиг болон цахим шуудангаар Сангийн яаманд хүргүүлэв.		100
4	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай 2015-06-19 № 62	2.1. Бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги хөтөлбөрийг таван жилээр төлөвлөж, холбогдох төлөвлөгөө, төслийг боловсруулан баталж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах; 2.2 Бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ыг боловсруулж Засгийн газрын 2015.10.05-ны 396 дугаар тогтоолоор батлуулсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн Дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан батлуулахаар боловсруулж байна. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг 2015 оны 7 дугаарсарын 9-ний өдөр батлуулсан. Энэ хуулийн зорилт нь өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.		30 100

		2.3. Энэтөгтоолын 2 дахь заалтын 1-д заасан стратеги хөтөлбөр, төлөвлөгөө, төслийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх;	-“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай” УИХ-ын тогтоол 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдөр буюу “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” батлагдахаас өмнө батлагдсан. -Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд холбогдох заалтыг тусгасан. “Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх 21:100” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэхээр 1,5 тэрбум төгрөг санхүүжилт тусгагдсан.		70
		2.4. Дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээмж болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллын дагуу гаргасан албан ёсны статистик үзүүлэлтэд үндэслэн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг авах.	Тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 7 дугаар бүлэг 7.3-д бодлогыг хэрэгжүүлэх үе шат бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ гэж заасан тул нэгдүгээр үе шатны үнэлгээ 2020 онд хийгдэнэ.		ХБ
5	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015-12-03 №: 108	3. Эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусад салбарын бүх шатны төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх зэргээр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн зардлын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлт бий болгох;	2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Санхүүгийн хэлтэст 1, Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтэст 2, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 1 нийт 4 сул орон тоонд томилгоо хийгдээгүйтэй холбогдуулан 4,138,967 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.		70

6	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай 2016-02-05 №: 19	2/Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 нийцсэн ба өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулах шаардлагатай хөтөлбөр байхгүй байна.	Хяналтаас хасах	100
7	Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай 2016.05.19 №46	2. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн хэмжээ, хилийн зааг, мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаа, тариалангийн технологи болон холбогдох бусад журмыг тогтоож, харьяалах төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэх	Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 328 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Халх гол сумын нутаг дэвсгэрт Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулж, улсын тусгай хэрэгцээнд авч байгаа газрын хэмжээ, хилийн заагийг тогтоосны зэрэгцээ бүсийн удирдлага, зохион байгуулалт болон газар ашиглалтын нийтлэг журмыг баталсан. Мөн энэхүү тогтоолоор бүсийн захиргааг байгуулан бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох, захирлыг томилон үйл ажиллагааг эхлүүлэх, бүсийн захиргааны дүрмийг батлах, газрын ашиглалтын үйл ажиллагааг бодлого зохицуулалт, удирдамж, чиглэлээр хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдад үүрэг болгосон. Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 25 дугаар тэмдэглэлийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А-102 дугаар тушаалаар “Мал эмнэлгийн хяналтын цэгт хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Тариалангийн технологийн хувьд ХХАА-н Сайдын 2015 оны А-110 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан ХАА-н “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсэд дагаж мөрдөх тариалангийн үйлдвэрлэл эрхлэх журмыг дагаж мөрдөж байна.		70
УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ					
1	Газар тариалангийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2012 № 02	1.1.Газар тариалангийн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх урамшууллын оновчтой хөшүүргийг бий болгох;	- Алслагдсан бүсэд буудайн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, буудайн тариаланг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбуудайн урамшууллыг бүсийн ялгавартайгаар олгох журам”-ын төслийг боловсруулан Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралданаар хэлэлцүүлэн 366 дугаар тогтоолоор батлуулав. 2016 оны төсөвт Буудайн урамшуулалд 5.6 тэрбум төгрөг батлуулсан байна. Урамшууллыг арилжааны банкаар дамжуулан хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох хэлбэрээр 5.6 тэрбум төгрөгийг		70

		<p>шилжүүлэн олгохоор тогтоолын төсөл боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. Тиймээс 2015 оны мөнгөн урамшууллыг гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн буудайн тонн тутамд нь 50.0 мянган төгрөг байхаар тооцож тариаланчдад олгох ажлыг зохион байгуулсан.</p> <p>- Цаашдаа шинээр батлагдсан Тариалангийн тухай хуульд нийцүүлэн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлсэн, хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээний биелэлттэй холбогдуулан мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх чиглэлээр асуудал боловсруулахаар төлөвлөж байна.</p> <p>2016 оны ургацаас гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн хүнсний буудайнд анх удаа чанарын ангилалаар мөнгөн урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай танилцуулга, тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2017 оны А/62 дугаар тогтоолоор 1 дүгээр ангилалын буудайн тонн тутамд 55.0 мянган төгрөг, 2-4 дүгээр ангилалын буудайн тонн тутамд 50.0 мянган төгрөг олгохоор шийдвэрлүүлснээр нийтдээ 726 аж ахуйн нэгж, иргэний 292.4 мянган тонн хүнсний буудайнд 14.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгов.</p>			
	<p>1.2. Органик газар тариаланг хөгжүүлэх төрийн бодлогын чиглэлүүдийг тодорхойлж, түүнд дэмжлэг үзүүлэх механизмыг боловсруулах</p>	<p>-Улсын Их Хурлын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Органик хүнсний тухай” хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, хуралдаанд оролцсон гишүүдийн 75,8 хувийн саналаар дэмжсэнээр батлагдсан ба 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө. Энэ хуулиар органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулна.</p> <p>- Түүнчлэн органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх болон хүнс үйлдвэрлэхэд тавигдах шаардлага, хэрэглэх бодис, органик орц найрлагыг тооцох, хамтын баталгаажуулалтын талаарх журам, жагсаалт, аргачлалыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэх эрхийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгохоор хуульчилсан.</p> <p>- Үүний дагуу органик газар тариалангийн журмын төслийг боловсруулан цахим хуудаст байршуулан санал авч байна.</p> <p>“Хүнсний тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт дурдсан төрөөс дэмжлэг, урамшуулал үзүүлж болох хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд органик хүнсний үйлдвэрлэл багтсан.</p>			70

			- 2016 онд БНСУ-ын АФАСИ ОУБ-ын байгууллагын санхүүжилтээр Ургамал хамгааллын хүрээлэн, Багануур дүүргийн Хөх монгол чацаргана БХН-ний чацарганы талбай дээр чацарганы органик тариалан эрхлэх иж бүрэн технологи боловсруулах судалгааны ажлыг эхлүүлэн хөнөөлт өвчин, хортонтой химийн бус арга технологиор тэмцэх, органик бордоогоор хөрсний үржил шимийг сайжруулах туршилт, судалгааны ажлыг явуулж байна.		
		1.3. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг ил тод нээлттэй зарчмаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллуулж, хөндлөнгийн хяналтыг бий болгох;	-ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/85 тоот тушаалаар Тариалан эрхлэлтийг дэмжих санг хувийн хэвшлийн оролцоо бүхий корпораци болгон зохион байгуулах, эрх зүйн орчинг бүрдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан. -Сангийн яамнаас “Засгийн газрын тусгай сангийн тухай” шинэчлэн найруулж буй хуулийн төсөлд саналаа тусгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр “Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн төсөлд Засгийн газрын тусгай сан -“Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-г компанийн хэлбэрт шилжүүлж, компанийн 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг үе шаттайгаар хувьчлахаар тусгасан бөгөөд Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжсэн тэмдэглэл гаргав. Жил бүрийн улирал тутам Үндэсний аудитын газраас болон ХХААХҮЯамнаас санхүүгийн аудит хийж байгаа болно.		70
		2.1. Дотоодын хэрэгцээнээс илүү гарсан улаан буудай, хивэг, тосны ургамлыг бололцоотой бүх хилийн боомтуудаар экспортлох боломжийг судалж шийдвэрлэх. Үүнтэй холбогдуулан үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах үүднээс үр тариа, гурилын импортын гаалийн албан татварын хувь хэмжээг уян хатан байлгах асуудлыг Гаалийн тарифын зөвлөлтэй хамтран боловсруулж, санал оруулах;	-Монгол Улсаас БНХАУ-д улаанбуудай, арвай, хивэг экспортлох ажлын хүрээнд тус улсаас 2012 оны 10 дугаар сард арвайн эрсдэлийн үнэлгээний баг Улаанбаатар хот, Дорнод аймагт, хивэгний эрсдэлийн үнэлгээний баг 12 дугаар сард Улаанбаатар хот, Дархан, Сэлэнгэ аймгуудад холбогдох мэргэжлийнбайгууллагуудтай хамтран ажилласан. Үр тарианы импортын гаалийн албан татварын хувь хэмжээг уян хатан байлгах асуудлыг судалж, УИХ-ын 1999 оны “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг УИХ-д өргөн барьсан. Уг тогтоолын төслийг 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1439 тоотоор Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Уг асуудлыг намрын ургац хураалтын дараа шийдвэрлүүлэхээр түр хойшлуулсан боловч ургац хураалтын үр дүнгээр хүнсний улаан буудайг экспортодгаргах боломжгүй болсон.		70

			-Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох “Үндсэн чиглэл”-ийн төсөлд тогтоолын төслийг оруулахаар саналаа тусгасан.Халх голын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаа, экспорт, импортыг дэмжих зорилгоор Өвдөг баян хошууны боомтыг байнгын ажиллагаатай болгох шийдвэрийг гаргуулав.		
		2.2. Чанар сайтай хүнсний буудайн хүрэлцэхүйц нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, стандартын шаардлага хангасан элеватор, агуулахад хадгалах, хадгалалтын явцад хяналт тавьж ажиллах;	-Улсын хэмжээнд 538.0 мянган тоннын багтаамжтай 19 элеваторын цогцолбор байгууламж ажиллаж байна. Үүнээс Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 182.0 мянган тонн, гурилын үйлдвэрүүдийн 276.5 мянган тонн, тариалан эрхлэгч аж ахуйн нэгжийн 80.0 мянган тонн багтаамжтай элеватор байна. Жил бүр элеваторуудад агуулахын ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, агуулахын засварыг бүрэн дуусгаж нөөцийн буудайг хүлээн авах бүрэн хийгдсэн. Мөн түүнчлэн хүнсний буудайн хадгалалтын явцад Мэргэжлийн хяналтын ерөнхий газар улирал тутамд хяналт тавьж, дүгнэлт гарган ажиллав. 2016 оны ургацаас ТЭДС-д 69.0 мянган тонн, Алтан тариа ХХК 90.0 мянган тонн, Улаанбаатар гурил ХХК 80.0 мянган тонн бусад гурилын үйлдвэрүүд 63.4 мянган тонн, нийтдээ 292.4 мянган тонн хүнсний буудайг хүлээн авч нөөц бүрдүүлэв. 2016 оны ургацаас Тариалан эрхлэлтийг дэмжих санд 69.0 мянган тонн хүнсний буудайн нөөц бүрдүүлсэн бөгөөд эхний 30.0 мянган тонныг нь гурилын үйлдвэрт борлуулаад байна. Хүнсний буудайн хадгалалтад байнгын хяналт тавьж Тариалан эрхлэлтийг дэмжих сантай хамтран ажиллаж байна.		100
2	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2015-07-09 №07	2. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг нэгдсэн зохион байгуулалт, салбар дундын удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд нөхөрлөл хариуцсан нэгж ажиллуулах, энэ чиглэлийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх	Энэ заалт нь ХХААХҮЯамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй болно. Биелэлтийг БОАЖЯам хариуцна.		үнэл-гээгүй

3	<p>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-11-23 №03</p>	<p>11. Улсын Их Хурлын 2012 оны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоолын 2.5 дахь заалтад заасны дагуу арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх ажлыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх;</p>	<p>Улаанбаатар, Дархан хотын гадна талд арьс, ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих арга хэмжээний төлөвлөгөө, тооцоог боловсруулж, үе шаттайгаар зохион байгуулах ажлын хэсгийг байгуулахаар оролцогч талуудтай зөвшилцсөн.</p> <p>-Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх, арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих асуудлаар Турк, Испани, Франц, Израйль, Япон, Голланд, Хятадын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, харьцуулсан судалгаа хийгдсэн. Мөн түүнчлэн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутгийн заагт 50 га газарт “Арьс, ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих Техник, эдийн засгийн үндэслэл судалгаа”-г тодотгож, цаашид хийх шаардлагатай ажлуудыг нарийвчилсан төлөвлөгөө гарсан байна. Арьс, ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах байршлыг дахин судалж тогтоох тухай Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 249 дүгээр тогтоол гарсан байна. Тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Дархан-Уул аймагт байгуулах Арьс ширний үйлдвэрлэлийн цогцолборын мастер төлөвлөгөө, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах” ажил тус тус хийгдсэн байна. Энэ ажлын үр дүнг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ-ын байнгын хороодод, Ерөнхий сайдад танилцуулжээ.</p> <p>-“Арьс, ширний үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 249 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх явцад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа арьс шир боловсруулах үйлдвэрүүд болон Дархан-Уул аймгийн иргэд Арьс, ширний үйлдвэрлэлийн цогцолборыг Дархан-Уул аймагт байгуулах асуудлыг дэмжихгүй байсан тул Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэл гарч, байршлыг сонгон шалгаруулсны үндсэн дээр дэд бүтэц байгуулах ажлыг эхлүүлэх нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>Түүнчлэн Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэлийн дагуу БОНХСайд, ҮХААСайд нар шинэ суурьшлын бүсийн газрын төлөв байдалтай очиж танилцаад, Засгийн газрын 2014 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар “Арьс, ширний үйлдвэрлэлийн цогцолборын байршлын тухай” асуудлыг хэлэлцүүлж, 356 дугаар тогтоол батлагдсан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс</p>	<p>Энэ тогтоол нэг удаагийн чанартай тул хасах саналтай байна.</p>	100
---	---	---	--	--	-----

			<p>рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ХХААХҮ-ийн Сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусганажиллаж байна. УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр Арьс, ширний үйлдвэрүүдийг Эмээлтийн үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017-12- 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ХХААХҮ-ийн Сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусган ажиллаж байна.</p> <p>Дээрхи үйлдвэрийн бүсийг үйлдвэрлэл технологийн паркийн хэлбэрээр зохион байгуулахаар төслийн бэлтгэл ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:</p> <p>“Аж үйлдвэрлийн парк”-ийн техник эдийн засгийн үндэслэл, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, Үерийн байгууламжийн ажлын зураг төсөл, Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл, Технологийн усан хангамжийн ажлын зураг төсөл, Ундны усан хангамжийн ажлын зураг төсөл, Паркийн техник технологийн түвшний үнэлгээ, паркийн цэвэрлэх байгууламжийн судалгаа зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулсан.</p> <p>9.Бүтээн байгуулалтын хувьд барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг байгуулаад байна</p> <p>Дээрхи шинэ бүсийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП” ОНӨТҮГ-аас үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн хүсэлт, материалыг судалж, “Эмээлт хөнгөн үйлдвэрийн ҮТП” ОНӨТҮГ-ын ирүүлсэн ТЭЗҮ хуучирсан, тодотгол хийсэн материал албажаагүй тул дахин боловсруулах үүрэг өгч буцаан дахин шинэчилсэн хүсэлт, материалыг судалж, ЗГ-ын 2017 оны 6-р сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 178-р тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.</p>		
		<p>14. Тогтоолынбиелэлтийн явцыг 2016 оны намрын чуулганы хугацаанд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Байгаль орчин, аялал жуулчлалын</p>			<p>100</p>

		яам /Д.Оюунхорол/, Барилга, хот байгуулалтын яам /Г.Мөнхбаяр/, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /Ц.Дашдорж/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /П.Сэргэлэн/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н Цагаанхүү/, нийслэлийн Засаг дарга /С.Батболд/-д тус тус даалгасугай			
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ					
1	“Нээлтэй хаалганы өдөр” зохион байгуулах тухай 2007-05-24 №:97	2. Бүтэн жилийн турш иргэдээс ирүүлсэн бүтээлч, ажил хэрэгч саналыг гүйцэтгэх удирдлагын байгууллагууд, холбогдох албан тушаалтан хүлээн авах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд үзүүлж байгаа эерэг үр дүн, үр нөлөөг нэгтгэн дүгнэж, ард түмэндээ мэдээлж байдаг эргэх холбооны тогтолцоог Засгийн газрын хэмжээнд бүрэлдүүлэн ажиллах нь зүйтэй гэж үзсүгэй.	Засгийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу ХХААХҮЯ-ны “Нээлтэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг 2017 оны 6-р сарын 9-10-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр иргэд, хэрэглэгчдэд хүнсний салбарын эрх зүйн актууд болон салбарт баримталж буй бодлого, тэдгээрийн хэрэгжилт, тус яамнаас хүнсний үйлдвэрлэлд олгодог зөвшөөрөл зэрэг холбогдох мэдээллийг өгч, хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах зэрэг сурталчилгааны материал хэвлүүлж, хэрэглэгчдэд тарааж сурталчлав. Мөн арга хэмжээний үеэр дотоодын үйлдвэрлэгчдийг төлөөлж хөнгөн, хүнс, жижиг дунд эрхлэгчдээс бүрдсэн 82 аж ахуйн нэгж оролцож, хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ үйлдвэрийн үнээр зарж борлуулан сурталчиллаа. Мөн мал аж ахуйн салбарын төрийн 10 байгууллага оролцов. Түүнчлэн “Дэлхийн сүүний өдөр” арга хэмжээг “Эх орны сүү-Эрүүл хүнс” уриан дор 2017 оны 6 дугаар сарын 01-10-ны өдрүүдэд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Монголын сүүний нэгдсэн холбоо, Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлтэй хамтран сүү хэрэглэх ач холбогдол, сүүний хэрэглээг нэмэгдүүлэх талаар сурталчилгааны ажлуудыг тус тус зохион байгууллаа.Өргөдөл гомдлын хагас жилийн тайлан мэдээ 07 сарын 05-нд гарах тул эхний улирлын байдлаар тайлагнав. Тус яаманд 2017 оны 1 дүгээр улиралд бичгээр 72, 11-11 төвөөр дамжуулан 29, цахим хаягаар 3, утсаар 2, нийт 106 өргөдөл, гомдол, санал хүсэлт, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлснийг хүлээн авч судлан зохих хариуг өгч ажиллаа. Нийт өргөдөл, санал хүсэлтийг агуулгаар нь ангилвал хамгийн олон ирсэн нь дэмжлэг, тусламж үзүүлэхийг хүссэн өргөдөл бөгөөд нийт		70

			<p>өргөдлийн 27,3 хувь 29 байна Нийт 106 өргөдлөөс Санал 35 / 33,0% Хүсэлт 60 / 56,6% Мэдээлэл 2 / 1,8% Гомдол 9 / 8,4%</p> <p>1.Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр дэмжлэг хүссэн 29 /27,3% 2.Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын ажилтай холбоотой 24 / 22,6% 3. Салбарын шагнал урамшуулалтай холбоотой 13 /12,2%</p>		
2	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2013.06.10 № 88</p>	<p>1. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх “шилэн данс”-ны тогтолцоонд шилжих;</p>	<p>-Шилэн дансны тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллага, төслийн нэгж, Засгийн газрын тусгай зориулалтын сан, төрийн өмчийн үйлдвэр газар зэрэг нийт 47-н байгууллага аж ахуйн нэгжийн 131 албан тушаалтан шилэн дансны сайтад мэдээлэл оруулах эрх авч, http://shilendans.gov.mn/org/19 нэгдсэн системд 1041 удаагийн хандалтаар 2206 мэдээллийг байршуулж, төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод болгох, иргэд мэдээ, мэдээллийг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар авах нөхцлийг бүрдүүлж ажилласан байна.</p> <p>-Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны IV улирлын байдлаар дотоод аудит хийх нэгдсэн удирдамж”ийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах сайдын багц, яамны аппарат, агентлаг, харьяа байгууллага нийт 10, ТӨААТҮГ-3, ТӨХК-1, төсөл хөтөлбөр-6, аймгуудын ХХААГ-21, ТЭДС-ийн 6 салбар буюу нийт 47-н байгууллага хамруулан шалгасан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын байгууллагууд шилэн дансны сайтад бүрэн хамрагдсан бөгөөд, шилэн дансны цахим хуудсанд 2016 онд нийт 6620 мэдээлэл байршуулахаас 6456 мэдээлэл байршуулж хуулийн хэрэгжилт 98,2 хувьтай байна.</p> <p>-Шилэн дансны сайтад бүртгэлтэй бүх байгууллагууд 2017 онд Шилэн дансны тайланг Сангийн яаманд 1-р улирлын тайланг цахим хэлбэрээр хугацаанд нь илгээсэн байна.</p>	100	
		<p>2. Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад тавих иргэний хяналтын тогтолцоо хийгээд өнөөгийн эрх зүйн орчны талаар</p>	<p>-Шилэн дансны мэдээллийг олон нийтэд түгээх иргэний хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хуулийн хэрэгжилтийн талаар олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авахын тулд яамны http://www.mofa.gov.mn/new/ цахим хуудсанд “Шилэн данс” булан</p>	100	

		олон нийтэд сурталчлах, иргэдийн санал дүгнэлтийг хүлээн авсан эсэхийг эргэж мэдэгдэж байх тогтолцоог нэвтрүүлэх.	нээж, шилэн дансны нэгдсэн сайтын http://shilendans.gov.mn/org/19 хаягтай холбон тус яамны болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төв, орон нутгийн 47 байгууллагын мэдээллийг оруулж буй байдал, төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагаанд хяналт тавих нийтэд нээлттэй болгох ажлыг зохион байгуулсан. -Яамны http://www.mofa.gov.mn/ хаягаар иргэдийн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр холбогдох албан тушаалтанд хүргүүлэн хариу арга хэмжээ авч ажиллаж байна.		
3	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.12.02 №158	1.2 Суурьшлын бүс, тариалангийн болон бэлчээрийн хөрсний доройтолд дүгнэлт гаргаж хөрс бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх богино, дунд, урт хугацааны бодлогын нэгдсэн хөтөлбөр боловруулан батлах, хэрэгжүүлэх	-Хөрс хамгаалах тухай Ерөнхийлөгчийн зарлигийн төсөлд санал хүргүүлэн, хэлэлцүүлэгт танилцуулга хийж оролцсон бөгөөд 2016 оны 12 сарын 02-ны өдөр батлагдсан. Энэхүү ажлын хүрээнд суурьшлын бүс, тариалангийн болон бэлчээрийн хөрсний доройтлыг бууруулах нөхөн сэргээх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2016 оны 11 сарын 02-ны өдрийн А-89 дүгээр тушаалаар Хөрс үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн 2 дугаар дэд хэсэгт тариалангийн болон бэлчээрийн хөрсийг хамгаалах нөхөн сэргээхтэй холбоотой хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, 5 дугаарт дэд хэсэгт нөхөн сэргээх, авах арга хэмжээний талаар санал соллоцож салбарын чиглэлээр шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэн хамтран ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Хөрс бэлчээр хамгаалах тухай” зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын мэдээллийн санг бүрдүүлэх, түүнийг баяжуулах, ашиглах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээний талаар саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газрын даргын хамтарсан А/116 дугаар тушаалаар нийтдээ 23 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулав.		30

		<p>1.3 Хөрс, бэлчээрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгож, жил бүр бүртгэх</p>	<p>“Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г шинэчлэх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, үйл ажиллагаанд тулгуурлан уг ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан тусгах зорилгоор шаардлагатай мэдээ мэдээллийг бэлтгэх ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны ТНБД, ГЗБГЗЗГ-ын даргын хамтарсан 2017 оны А/117 тоот тушаалаар нийтдээ 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулав. Ажлын хэсэг 3 удаагийн уулзалт зохион байгуулан хөдөө аж ахуйн мэдээллийн санд оруулах ерөнхий бүтэц болон 26 бүлгийн 110 нэр төрлийн мэдээллийн жагсаалтыг дэлгэрэнгүй гаргаж танилцуулаад байна.</p>		30
		<p>1.4 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээр ашиглах уламжлалт арга ажиллагааны дэвшилтэт хэлбэрийг хэрэгжүүлж, хөрс бэлчээр сайжруулах дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх</p>	<p>Бэлчээр ашиглах уламжлалт арга, бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, бэлчээрийн доройтлоос урьдчилан сэргийлэх, мал аж ахуй эрхлэх уламжлалт олон дэвшилтэд арга зам сэдэвт сургалтыг Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой хамтран Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл, Дорнод аймгуудын ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, ХХААГ, Газрын харилцаа, барилга төлөвлөлтийн газар, сумдын Газар зохион байгуулалтын хэлтэс, МЭҮТ-ийн холбогдох мэргэжилтнүүд, багийн Засаг дарга, бэлчээр ашиглагчдын хэсгийн дарга, малчид зэрэг 200 гаруй хүнийг хамруулан зохион байгуулав.</p>		0
		<p>1.5 Хөрс, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээнд зарцуулах зардлыг 2019 оноос эхлэн жил бүр орон нутгийн төсөвт тусгаж хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, хяналт тавих</p>	<p>-Тариалангийн талбайн хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хөтөлбөр боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт тусгах ажлыг зохион байгуулна.</p> <p>2017 онд улсын төсвийн хөрөнгөөр 12 аймаг, аймаг дундын отрын бэлчээр нийт 580.0 мян га-д үлийн цагаан оготнотой микробиологийн болон энгийн механик аргаар тэмцэнэ. Үүнээс: Баянхонгор, Өвөрхангай аймгийн 100.0 мянган га бэлчээрт микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэхэд зориулж 200.0 тн бактерийн бэлдмэл худалдан авч, ажил, үйлчилгээний хөлсийн хамт 400.0 сая төгрөг зарцуулна. 10 аймаг, аймаг дундын отрын бүс нутагт 480 мян га бэлчээрт 768.0 сая төгрөгөөр энгийн механик аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулна.</p> <p>Эхний хагас жилийн байдлаар Баянхонгор, Өвөрхангай аймгийн 50.0 мянган га бэлчээрт микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэхэд зориулж 100.0 тн бактерийн бэлдмэл худалдан авч, ажил, үйлчилгээний хөлсний хамт 200.0 сая төгрөгийн АГГ 170407/04-052 дугаар гэрээг “Шим” ХХК-тай байгуулж ажлын гүйцэтгэлд хяналт</p>		30

		<p>тавин хүлээн авлаа.</p> <p>2017 онд Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймагт 89.8 мян.га-д царцаатай тэмцэх бэлтгэл ажлын хүрээнд 119.0 мянган төгрөгөөр царцаатай тэмцэх 13500 литр Карате бодисыг худалдан авч Баян-Өлгий аймагт 6.0 мянган литр, Ховд аймагт 6.0 мянган литр, Говь-Алтай аймагт 1.5 мянган литрийг хуваарилан хүргүүлж 6 дугаар сард хийх ажлыг гүйцэтгэж байна. Ажил, үйлчилгээний хөлсөнд 360.0 сая төгрөг зарцуулна.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А-131 дугаар тушаалаар Үлийн цагаан огтоно, царцааны тархалтын хөнөөлийн тодотгох судалгааг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй 170503/04-069 дугаар гэрээг байгуулан гүйцэтгүүлж байна. Ажлын санхүүжилт нь 17.0 сая төгрөг, огтоно, царцаатай тэмцэх ажлын үйл явцад хяналт тавих томилолтын зардалд 3.5 сая төгрөг төлөвлөсөн байна.</p>		
	1.6 Хөрс хамгаалах үндэсний өдөртэй болох	Суурьшлын, газар тариалангийн болон бэлчээрийн хөрсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн төлөөлөлтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллан “Хөрс хамгаалах өдөртэй болох тухай” Засгийн газрын 2017 оны 5-р сарын 24-ны өдрийн 149 дүгээр тогтоолыг батлуулна. Энэ ажлын хүрээнд газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөрс хамгаалах, түүнийг нөхөн сэргээх, хот, суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах, саармагжуулах талаар тухайн жилд зохион байгуулах ажил, арга хэмжээг төлөвлөж, тэдгээрийг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.		100
	3. Зарлигийн биелэлтийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгч болон олон нийтэд тайлагнаж байхыг Засгийн газарт үүрэг болгосугай.	-Зарлигийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлын тайланг жил бүр олон нийтэд тайлагнах ажлыг зохион байгуулна.		ХБ
ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ				
1	1. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шинжээчдийн дүгнэлтийг харгалзан Мал, эмнэлгийн албаны үндэсний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх,	УИХ-ын чуулганы Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн, Чуулганы 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар тус тус анхны хэлэлцүүлэгт орсон бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж байна.		30

<p>Малын эрүүл мэндийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай 2011.06.08 23/20</p>	<p>бодлого, хяналт, үйлчилгээг мэргэжлийн удирдлага, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, удирдлагатай байхаар зохион байгуулах,</p>			
	<p>3.Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, эрт сэрэмжлүүлэх, хариу авах арга хэмжээний бэлэн байдлын чадавхийг бэхжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газрын дэргэд шүлхийн вакцин, оношлуур, ариутгал халдваргүйтлийн бэлдмэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, дуудлагын машин бүхий шуурхай ажлын нэгж байгуулах</p>	<p>Шуурхай нэгж байгуулагдаагүй.</p>		0
	<p>4.Сум, багийн мал эмнэлгийн үйлчилгээний анхан шатны хувийн нэгжүүдийн материаллаг баазыг бэхжүүлэх, малын үзлэг, шинжилгээний хашаа, угаалгын тоног төхөөрөмж, оношлогоо, шинжилгээний лаборатори, эм, биобэлдмэл, вакцин хадгалах зориулалтын агуулахаар хангах.</p>	<p>“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 2013, 2014 онд 10 аймгийн 134 суманд (давхардсан тоогоор) 96 иж бүрдэл зөөврийн хашаа, 5.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 107 иж бүрдэл мал угаалгын төхөөрөмж тус тус нийлүүлсэн. Мал угаалгын зөөврийн төхөөрөмж нь манай орны бэлчээрийн мал аж ахуйн онцлогт тохиромжгүй байгаа тул ашиглалт хангалтгүй байна. Харин зөөврийн хашаа нь мал эмнэлгийн арга хэмжээг зохион байгуулахад хөдөлмөр, хүн хүч цаг хугацаа хэмнэсэн чухал төхөөрөмж учир Мал эмнэлэг, үржлийн тасаг, нэгжүүд үр дүнтэй ашиглаж байна. Эдгээр хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газрын орон нутгийн өмчид бүртгүүлэн ашиглаж байгаа болно.</p>		70
<p>5.Малын эмч, мал зүйч, зоотехникч нарыг хөдөлмөрийн хүнд, хортой, халдвартай нөхцөлд хамруулах асуудлыг судлан шийдвэрлэх</p>	<p>Малын эмчийн хөдөлмөрийг хүнд нөхцөлд хамруулж хөнгөлөлттэй нөхцлөөр тэтгэвэр тогтоолгох саналыг 2006 оноос эхлэн зохих яам, холбогдох газруудад удаа дараа хандаж ажилласны үр дүнд НХХ-ийн сайдын 2004 оны “Тэтгэвэрийг хөнгөлөлттэй нөхцлөөр тогтоох, газрын дор болон хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-ыг баталсан 77 дугаар тушаалын 4.15 дахь хэсгийн “Хөдөө аж ахуйн салбарын малын эмч, санитарч, тракторчин, комбайнч (1995 оноос өмнөх хамаарна) гэсэн заалтын (1995 оноос өмнөх хамаарна) гэснийг 2015 оны ХАХНХ-ын сайдын А/113 тушаалаар хасаж шийдвэрлэсэн. Ингэснээр малын эмч, санитарч нарын ажил хөдөлмөр хүнд, хортой нөхцөлд хамрагдсан.</p>		70	

			<p>Мөн малаас хүнд халдварладаг бруцеллёз өвчний халдварлах нөхцөл байдал, халдвар авсан хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоох аргачилал, өвчилсөн хүний шаналгаа, насжилтын байдлыг тодорхойлуулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Энэ хүрээнд мал эмнэлгийн зарим ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хэмжилт, хөдөлмөрийн нөхцлийн судалгаа, үнэлгээ хийлгэх тухай МЭҮГ-ын даргын 2016.04.21-ний өдрийн А/18 дугаар тушаал гарсан. Уг тушаалд заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяа “Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв”-тэй 2016.04.22-ны өдөр 2016/14 дугаартай гэрээ байгуулан ажиллаж, мал эмнэлгийн анхан шатны нэгжийн ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн бүрэн хэмжээний зураг авалтыг хийлгэсэн ба тайлан, үнэлгээг 2016.06.27-нд хүлээн авсан. Тус байгууллагын үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн бруцеллёз өвчнийг мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтанд оруулахаар ажиллаж байна.</p> <p>Мал зүйч мэргэжлийг хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамруулах зорилгоор ажлын байрны нөхцөлд судалгаа, үнэлгээ хийлгэх саналаа дээрх байгууллагад дахин хүргүүлээд байна.</p>		
		<p>6.Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн техник, технологийг шинэчлэх, шинжилгээний болон халдвар хамгаалал, биоаюулгүй байдлын чадавхийг сайжруулах,</p>	<p>ХХААЯ-наас захиалан ХААГ-ын зарласан 181 сая төгрөгний өртөг бүхий “МЭЭСБУЛ-ийн техник технологийг сайжруулах нь” тендерт 2014 оны 05-р сарын 30 ны өдөр “MBES” компани шалгарсан.</p> <p>Захиалагч байгууллага /ХХААЯ/, хүлээн авагч байгууллагын /МЭЭСБУЛ/ эрх бүхий албан тушаалтныг оролцуулан тус компанитай бараа нийлүүлэх гэрээ байгуулсан. “MBES” компани нь гэрээнд заасан 180257.0 мянган төгрөгний үнэ бүхий 16 нэрийн 19 багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх байснаас 85 сая 987 мянган төгрөгийн үнэ бүхий 8 нэрийн 10 багаж, тоног төхөөрөмжийг ХХААЯ ны ТНБД-ын 2015 оны А-376 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт 2015 оны 10-р сарын 19-ний өдөр хүлээлгэн өгсөн. Энхүү тендерээр нийлүүлэгдэх 19 багаж, тоног төхөөрөмж нь МЭЭСБУЛ-д нэн шаардлагатай төдийгүй халдвар хамгаалал, биоаюулгүйн байдлыг сайжруулах, эм, биобэлдмэлийн сорилт, шинжилгээний түвшинг дээшлүүлж чадавхийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Гэвч бактерийн эндотоксин тодорхойлогч, карл фишерийн аппарат, СО₂ бүхий термостат, шахмал /универсал/ тодорхойлогч, давхар ус нэрэгч, автомат потенциометр, автоклав, плат холигч зэрэг багаж тоног төхөөрөмжүүдийг гэрээний дагуу нийлүүлж чадаагүй байна.</p>		30

	<p>"Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2012-06-25</p> <p>2012_19/12</p>	<p>3. Инженерийн хийцтэй худаг, усралтын систем, цас, борооны усыг хуримтлуулах цөөрөм, усан санг шинээр барих, сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх, хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;</p>	<p>-2016 онд улсын төсвийн 745.1 сая төгрөгөөр 42, гадаадын төсөл, хөтөлбөрийн 371.3 сая төгрөгөөр 27, орон нутгийн төсвийн 2.8 тэрбум төгрөгөөр 259 инженерийн хийцтэй худаг, малчдын санаачлагаар 354 гар худаг, нийт 682 худаг гаргасан нь 775.2 мянган га бэлчээр, 2.7 мянганмалчин өрх, 1.9 сая малын усан хангамжийг нэмэгдүүллээ. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад зориулж 2017 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд 4.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн санал тусгаснаас 2.0 тэрбум төгрөг батлагдав. Үүнээс 2.0 тэрбум төгрөгөөр аймаг дундын оторын бүс нутаг, 17 аймгийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад зориулан 110 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргахуваарийг ХХААХҮСайдын А-74 дугаар тушаалаар батлуулав. Хуваарьт тусгагдсан аймгуудад инженерийн хийцтэй худгуудыг шинээр гаргах ажлыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу тендер зарлан гүйцэтгүүлэх ба аймгуудаас шинээр худаг гаргах газруудын саналыг авч нэгтгэн боловсруулах болон бусад бэлтгэл ажил хийгдэж байна.</p>		70
2		<p>5. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй хоол тэжээлийн дутлыг бууруулахад чиглэсэн баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, эмчилгээ сувиллын газар, бага насны хүүхдийн нэмэгдэл хоолны үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх;</p>	<p>-ЭМСЯ-наас санаачилсан “Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай” хуулийн төсөл боловсруулах /2016-2017 он/ ажлын хэсэгт ажиллан, төслийг боловсруулан 2017 оны УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан.Уг хуульд бага насны хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах, үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх талаар заалтууд тусгагдсны дагуу бага насны хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэр барих саналыг 2017 онд хүргүүлснээр Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр үйлдвэр барих Техник эдийн засгийн тооцоог хийхээр төлөвлөөд байна.</p> <p>- Баяжуулсан хүнсний тухай хуулийн үзэл баримтлалыг УИХ-аар батлуулсан ба 2016 оны 12-р сарын 28-ны өдөр УИХ-д УИХ-ын гишүүн А.Ундраа, Ц.Гарамжав, Б.Батзориг нар “Баяжуулсан хүнсний тухай хуулийн төсөл”-ийг өргөн мэдүүлсэн. Үүний дагуу Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2017 оны 4-р сарын 26-ны өдрийн хуралдаанаар Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн 90,9 хувь нь дэмжсэн тул УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулахаар болсон.</p> <p>- Улсын Их Хурлын 2017 оны 5-р сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганаар Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн 90,9 хувь нь дэмжсэн учир Байнгын хорооны 2017 оны 05-р сарын 16-ны өдрийн 04 тоот тогтоолоор ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан.</p>		0

			-Баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, шим тэжээлийн дутлаас сэргийлэхэд чиглэсэн Төв Евроазийн орнуудын чуулганыг 2017 оны 06-р сарын 7-9-ны өдрүүдэд УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Байгаль орчин хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эрүүл мэнд, спортын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулж, хүн амын хоол, шим тэжээл, баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийн талаарх туршлагын талаар 3 өдрийн хуралдааныг зохион байгуулж, санал солилцов.		
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ					
1	Төлөвлөгөө батлах тухай (Төрөөс малчдын талаар баримтлах бодлого) 2009.07.08 № 208	3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд үүрэг болгосугай.	- Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээллийг жил бүр ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна. - 2016 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг яамны ХШҮДАГ-аар үнэлүүлэн мэдээллийн санд оруулав. Монгол мал” хөтөлбөр, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг улсын хэмжээнд удирдан зохино байгуулах, зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хороог ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А-52 дугаар тушаалаар шинэчлэн байгуулав.		30
2	Төлөвлөгөө батлах тухай (Монгол мал хөтөлбөрийн) 2010.09.01 № 222	3."Монгол мал" үндэсний хөтөлбөрийн биелэлт, үр дүнг нэгтгэн, жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд үүрэг болгосугай.	Тайланг 2015 онд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийн ерөнхий дундаж үнэлгээ 67.8 хувьтай буюу “Хангалттай” гэж үнэлэгдэж байна. Үүнээс нэг дүгээр тэргүүлэх чиглэлийн биелэлт 74.0 хувьтай, хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн биелэлт 74.3 хувьтай, гуравдугаар тэргүүлэх чиглэл 57.8 хувьтай, дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл 60.5 хувьтай, тавдугаар тэргүүлэх чиглэл 72.6 хувийн биелэлттэй байна. Уг хөтөлбөр нь 2021 он хүртэл үргэлжлэх бөгөөд хэрэгжилт удаашралтай болон хэрэгжээгүй арга хэмжээг 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 11 арга хэмжээ удаашралтай хэрэгжиж, 11 арга хэмжээгүй байна. 2016 онд хэрэгжүүлсэн ажлын үнэлгээний тайлангийн дүнг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, яамны “АСУ” программын төлөвлөгөө тайлан мэдээллийн санд оруулав.		70
3	Аймаг дундын	2. Баруун бүсийн аймаг дундын	-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2014 оны газрын		70

	<p>отрын бэлчээрийн зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай</p> <p>2012.12.08 № 158</p>	<p>отрын бүс нутгийг ашиглахад шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.</p>	<p>нэгдмэл сангийн урьдчилсан тайлангаар манай улсын бэлчээр хадлангийн талбай 2012-2013 онд 112.7 сая.га, 2014 онд 112.4, 2015 онд 112.3 сая.га байна. Улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад 782.5 мянган га газар нутаг бүхий 9 отрын нөөц бэлчээрийг улсын хамгаалалтад аваад байна.</p> <p>-2017 оны хагас жилийн байдлаар Ховд аймаг дахь улсын тусгай хэрэгцээний “Баяннуруу”-ны отрын бүс нутгийн бэлчээрийн ашиглалтын байдалд хяналтын тавих урсгал зардалд мэргэжилтний цалинд 3,211.7 мян.төг, шатахуунд 385.0 мян.төг зарцуулсан байна. Ажлын байрны ажиллах нөхцөл бололцоог сайжруулах ажлын хүрээнд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүжилтээр тус отрын бүс нутаг мотоцикл, компьютер, ширээ, сандалаар хангасан болно.</p>		
4	<p>Баруун бүсийн тариаланг хөгжүүлэх тухай</p> <p>2013.11.09 № 366</p>	<p>3.Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөв, гадаад орон болон олон улсын байгууллагын зээл, тусламж, төсөл арга хэмжээнд хамруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Гадаад харилцааны сайд Л.Болд нарт тус тус үүрэг болгосугай./</p>	<p>-“Алслагдсан бүсэд газар тариаланг сэргээн хөгжүүлэх”, “Таримал ургамлын үр үржүүлэг, таримлын сэлгээ, шинэ сортуудыг сорих, нутагшуулах, сорт сорилтын төвүүдийг сэргээх”, “Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл нийлүүлэлтийн хэлхээн дэх логистик урсгалын судалгаа” ТЭЗҮ Үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерүүдийг шалгаруулж, “Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо” ТББ, УГТСЭШХ, “Монголын логистикийн холбоо” ТББ-уудаар гүйцэтгүүлж ТЭЗҮ-г хүлээн авлаа. Увс аймгийн Баруун туруун суманд 20.0 мянган тонн буудай хүлээн авч хадгалах элеваторыг БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр барих ажлыг эхлүүлж хятадын талтай гэрээ байгуулаад байна.</p> <p>-2015 онд Баруун бүсэд нийтдээ 5.8 мянган га-д үр тариа, 1.6 мянган га-д төмс, 1.3 мянган га-д хүнсний ногоо тарьж 2012 оныхоос үр тариа 5.6 мянган га-р, төмс 0.5 мянган га-р буурсан бол хүнсний ногоо 71 га-р өссөн үзүүлэлттэй байна. Хураан авсан ургац үр тариа 5.3 мянган тн, төмс 18.2 мянган тн, хүнсний ногоо 15.0 мянган тн хурааж, гангийн улмаас үр тариа 2 дахин, хүнсний ногоо 1.6 мянган тонн, төмс 4 мянган тонноор буурсан дүнтэй байна.</p> <p>- Баруун бүсийн тариалан хөгжүүлэх чиглэлээр тусгайлсан хөрөнгө батлагдаагүй. Харин бүсийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор баруун бүсийн тариаланчдад олгох урамшуулалын хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн гурилын үйлдвэрлэлд нийлүүлсэн буудайн тонн тутамд 50.0-150.0 мянган төгрөгийн урамшуулал олгож ирсэн. Шийдвэрийн дагуу 2015 онд баруун бүсийн тариаланчдын гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн хүнсний буудайн тонн тутамд 50.0 мянган төгрөгийн урамшуулал олгож байсан бол 2016 онд анх удаа</p>		70

			<p>чанарын ялгаатайгаар урамшуулал олгосон бөгөөд баруун бүсийн 107 аж ахуйн нэгж, иргэдийн гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн 6.9 мянган тонн хүнсний буудайн тонн тутамд 75.0 мянган төгрөг буюу нийтдээ 517.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгов.</p> <p>2016 онд хаврын тариалалт, ургацын урьдчилсан баланс, ургац хураалтын дүнгийн танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд тухай бүр нь танилцуулж шийдвэр гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллав.</p> <p>УИХ-ын нэгдсэн чуулганд ерөнхий сайд 2017 оны хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцын талаар танилцуулга хийх болсонтой холбогдуулан асуудлыг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлэв.</p>		
5	<p>Журам, жагсаалт, хуваарь батлах тухай 2015.07.07 № 286</p>	<p>3. Ус цаг уурын сүлжээг түшиглэн улсын хэмжээнд хийж байгаа цөлжилтийн хяналт-шинжилгээ, өвөл, хаврын бэлчээрийн даац, багтаамжийг тодорхойлох судалгааны ажлыг цаашид хамтран зохион байгуулж байхыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар нарт үүрэг болгосугай.</p>	<p>-Монгол улсын Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2015-2016оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж гаргасан.</p> <p>-Өвөл хаврын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 60.0 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 40.0 хувь нь хүрэлцээ муутайгаас орон нутгийн ЗДТГ отор хийж өвөлжих өрх, малын тоог тохиролцон гэрээ байгуулан өөр аймгийн нутагт 2472 өрхийн 1.1 сая, өөрийн аймгийн бусад сумын нутагт 7195 өрхийн 2.7 сая, аймаг, дундын тусгай хэрэгцээний отрын бүс нутагт 1254 өрхийн 811.0 мянга, хилийн зурвас газарт 2597 өрхийн 977.0 мянга, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 3962 өрхийн 1595.0 мянган мал нийт 17.5 мянган өрхийн 7.2 сая мал отроор өвөлжиж, хаваржихаар зохион байгуулалт хийгдсэн.</p>	70	
6	<p>Хөтөлбөр батлах тухай /“Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр”/ 2015.08.04 № 325</p>	<p>3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Сангийн сайд Ж.Эрдэнэбат, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>- Монгол Улсад 2016 онд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн /УХЭШХ/ болон Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн /УГТХ/ Эрдмийн зөвлөлийн хурлын дүгнэлтийг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, 2016 оны 02 сард БОНХАЖ-ын сайд, ХХАА-н сайд, ЭМС-ын сайдын хамтарсан А-51/А-28/57 тушаалаар батлуулж улсын бүртгэлийн 3626 дугаарт бүртгүүлээ. БОНХАЖЯ нь 2015 оноос эхлэн ургамал хамгаалахад ашиглах химийн бодисоос бусад бодисыг энэхүү жагсаалтад оруулан батлуулах боломжгүй хэмээн мэдэгдсэн тул Ургамал хамгааллын тухай хуулийн 8.1.7 заалтын дагуу Ургамал хамгааллын арга хэмжээнд ашиглах химийн бодисоос бусад бодисыг бүртгэх, турших, хэрэглэх журмын төслийг</p>	70	

		<p>боловсруулан Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 05 сарын 02-ны өдрийн А-63 тоот тушаалаар батлуулж 2016 оны 05 сарын 20-ны өдөр улсын бүртгэлийн 125 дугаарт бүртгүүлсэн. Энэхүү журам батлагдсанаар газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах биологийн бэлдмэлийн хяналт сайжрав. Үүний дагуу шинээр бүртгэлд орж байгаа химийн болон биологийн бодисын зохистой аюулгүй хэрэглээний талаар заавар, зөвлөмж боловсруулж олон нийтэд түгээх, сургалт семинарыг зохион байгуулах шаардлагатай байна.</p> <p>- Монгол Улсад 2015 онд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн /УХЭШХ/ болон Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн /УГТХ/ Эрдмийн зөвлөлийн хурлын дүгнэлтийг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, 2015 оны 02 сарын 25- ны өдрийн БОНХАЖ-ын сайд, ХХАА-н сайд, ЭМС-ын сайдын хамтарсан А-80/А-28/73 тушаалаар батлуулав. БОНХАЖЯ нь 2015 оноос эхлэн ургамал хамгаалахад ашиглах химийн бодисоос бусад бодисыг энэхүү жагсаалтад оруулан батлуулах боломжгүй хэмээн мэдэгдсэн тул Ургамал хамгааллын тухай хуулийн 8.1.7 заалтын дагуу Ургамал хамгааллын арга хэмжээнд ашиглах химийн бодисоос бусад бодисыг бүртгэх, турших, хэрэглэх журмын төслийг боловсруулан ХХААЯ-ны цахим хуудсанд байршуулан холбогдох мэргэжлийн байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, аж ахуйн нэгж, холбоод, ТББ –ыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан ба Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас гарсан зохих саналуудыг тусган батлуулах ажлыг зохион байгуулах шийдвэр гаргасан. Энэхүү журам батлагдсанаар газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах биологийн бэлдмэлийн хяналт сайжрав.</p> <p>- “Бэлчээр ашиглалтын журам болон бэлчээрийн даац, багтаамжийг тооцоолох аргачлал”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар байгуулан төслүүдийг боловсруулаад байна. Мөн бэлчээрийн газрын харилцааг зохицуулах “Бэлчээрийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж байна.</p> <p>- Монгол Улсад 2015 онд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээг УХЭШХ болон Дархан-Уул аймгийн УГТХ–ийн Эрдмийн зөвлөлийн хурлын дүгнэлтийг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, 2015 оны 02 дугаар сарын 25- ны өдрийн БОНХАЖ-ын сайд, ХХАА-н сайд, ЭМС-ын сайдын хамтарсан А-80/А-28/73</p>		
--	--	--	--	--

			<p>тушаалаар батлуулав. БОНХАЖЯ нь 2015 оноос эхлэн ургамал хамгаалахад ашиглах химийн бодисоос бусад бодисыг энэхүү жагсаалтад оруулан батлуулах боломжгүй хэмээн мэдэгдсэн тул Ургамал хамгааллын тухай хуулийн 8.1.7 заалтын дагуу Ургамал хамгааллын арга хэмжээнд ашиглах химийн бодисоос бусад бодисыг бүртгэх, турших, хэрэглэх журмын төслийг боловсруулан ХХААЯ-ны вэб хуудсанд байршуулан холбогдох мэргэжлийн байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, аж ахуйн нэгж, холбоод, ТББ-ыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан ба ХХАА-н Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас гарсан зохих саналуудыг тусган батлуулах ажлыг зохион байгуулах шийдвэр гаргасан. Энэхүү журам батлагдсанаар газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах биологийн бэлдмэлийн хяналт сайжрах ба харин үүний дагуу шинээр бүртгэлд орж байгаа химийн болон биологийн бодисын зохистой аюулгүй хэрэглээний талаар заавар, зөвлөмж боловсруулж олон нийтэд түгээх, сургалт семинарыг зохион байгуулах шаардлагатай байна.</p>		
7	<p>Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги батлах тухай</p> <p>2015.08.31 №353</p>	<p>2. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран баталж, хэрэгжилтийг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамба, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгасугай.</p>	<p>-“Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ий төслийг ЭМС-ын сайдын удирдлагын зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, дэмжсэн бөгөөд хурлаас гарсан шийдвэрийн дагуу төлөвлөгөөг ЭМС-ын болон ХХАА-н сайдын тушаалаар баталсан. БСШУ-ны сайдад батлуулахаар хүргүүлээд байна.</p> <p>Үндэсний стратегийн 3 дугаар зорилтын 2.3.3.1 болон 2.3.3.2. дахь - заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амд давсны хэрэглээний талаар мэдлэг, ойлголт олгох чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг Төв, Хангай, Баруун бүсийн 13 аймаг, Баруун бүсийн 5 аймаг, Зүүн бүсийн 3 аймаг, Говийн бүсийн 3 аймгийг хамруулсан “Хоол үйлдвэрлэлд эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь” сургалтыг зохион байгуулж, 1000 гаруй хоол үйлдвэрлэгч, мэргэжилтүүд оролцов. Мөн Дундговь аймгийн ЗДТГ-тай хамтран хоол үйлдвэрлэгч, ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд давсны хор уршиг, зохистой хооллолтын талаар хичээл заасан.</p> <p>Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор иоджуулсан давсны зохистой хэрэглээг хэвшүүлж, давс багатай хоол, хүнс үйлдвэрлэхэд үйлдвэрлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, иоджуулсан давсны ач холбогдлыг олон нийтэд сурталчилан таниулах ажлын хүрээнд “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аяныг 2 жилийн</p>		70

			<p>хугацаатай зохион байгуулах ажлыг Шадар сайд, ЭМ-ын сайд, ХХААХҮ-ын сайд нарын хамтарсан тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөж байна.</p> <p>Сүү, сүүн бүтээгдэхүүн болон давс үйлдвэрлэгч хувийн хэвшлийн төлөөллийг хамруулан Хүнс баяжуулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p> <p>Тус яамнаас УИХ-ын НББСШУБХ, ЭМЯ, ШУТИС, Харвардын эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй хамтран "Төв Евроазийн шим тэжээлийн анхдугаар чуулган"-ыг 2017 оны 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Чуулганд болон чуулганы үеэр зохион байгуулсан салбар хэлэлцүүлгүүдийн арга хэмжээнд АНУ, ИБУИИНВУ, Япон, ХБНГУ, Швейцар, БНХАУ, Казакстан, Тажикстан зэрэг орноос, мөн олон улсын байгууллага, Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл нийт 200 гаруй хүн оролцсон. Чуулганаас "Улаанбаатарын тунхаг" баримт бичгийг гаргасан.</p> <p>Чуулганы арга хэмжээний хүрээнд ХХААХҮЯ-нд 2017 оны 6 дугаар сарын 8-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж хүнс баяжуулахын ач холбогдлын талаар санал, мэдээлэл солилцсон.</p>		
8	<p>Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай</p> <p>2016-01-11 №37</p>	<p>2.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгох зээлийн хүүг 9 хувиар тогтоож, зээл олгох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад үүрэг болгосугай.</p>	<p>1.Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 37-р тогтоол Жижиг дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах 200.0 тэрбум төгрөгийг Хөгжлийн банкаар дамжуулан олгохоор баталсан бөгөөд үүнийг Сумын өрхийн бичил бизнест эрхлэгчдэд 46 тэрбум, Жижиг үйлдвэрийг дэмжих зорилгоор аймгийн дэд хороонд 47 тэрбум, Жижиг үйлдвэрийг дэмжих зорилгоор дүүргүүдэд 46 тэрбум, дунд үйлдвэрийн дэмжих зорилгоор 62 тэр бум төгрөгийн эх үүсвэрийг тус бүр хуваарилахаар төлөвлөсөн боловч Хөгжлийн банкнаас уг төслүүдийг санхүүжүүлэх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.</p> <p>2.ХХААХҮЯамны Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2016 онд нийт 165 иргэн, ААН-д 74,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөөс олгоод байна.</p>		30
9	<p>Жагсаалт батлах тухай</p> <p>2016-04-04 №:197</p>	<p>2. Гаалийн албан татвараас 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөх импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор,</p>	<p>2. Импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөхөөр хуульчилсантай холбогдуулан жагсаалтыг боловсруулж</p>		100

		<p>комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг 1 дүгээр, Нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөх импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулах шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Болор, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгасугай.</p>	<p>Засгийн газрын 197 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Энэ хугацаанд 7.9 мянган тонн бордоо, 233.8 тонн ургамал хамгааллын бодисыг гаалийн болон НӨАТ-гүйгээр импортлов.</p>		
10	<p>Журам батлах, мал эмнэлгийн хяналтын цэгийн байршил тогтоох тухай</p> <p>2016-05-09 №240</p>	<p>5. Гоц халдварт өвчинтэй тэмцэх зорилгоор байгуулсан бүсүүд болон хяналтын цэгт мал эмнэлэг, хорио цээрийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Б.Болор, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгт ажиллах албан хаагчдын цалин, үйл ажиллагааны зардлыг Нийслэлийн Мал эмнэлгийн газраас санал авч, ХХААХҮ-ийн Сайдын 2017 оны төсвийн багцад 546,618.2 мян.төгрөгийг батлуулсан байна.</p>		100
		<p>6. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,</p>	<p>Мал, амьтныг онц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүсчлэн</p>		70

		түүнтэй тэмцэх арга хэмжээг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүсчлэн хэрэгжүүлэх стратегийн ач холбогдлыг малчид, иргэдэд сурталчилж, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог төлөвшүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	хэрэгжүүлэх стратегийн ач холбогдлыг малчид, иргэдэд сурталчилж, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог төлөвшүүлэх зорилгоор мал, амьтныг онц халдварт өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө, бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Мал эмнэлэг, үржлийн газрын даргын тушаалаар шинэчлэн батлуулан ажиллаж байна. Тус ажлын хэсгээс боловсруулсан “Мал, амьтны гоц халдварт өвчний бэлэн байдлын төлөвлөгөө”, “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх стратеги 2018-2023,” “Бог малын мялзан өвчинтэй тэмцэх стратеги 2018-2023” төслүүдийг үндэсний болон олон улсын мэргэжилтнүүд оролцсон4 удаагийн уулзалтаар хэлэлцүүлсэн бөгөөд олон улсын зөвлөхүүдийн санал дүгнэлтийг тусган эцэслэн боловруулах уулзалтыг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна.Мал, амьтны гоц халдварт өвчнийг эрт илрүүлэх тогтолцоог төлөвшүүлэх хүрээнд Бог малын мялзан өвчний олон улсын экспертүүдийн уулзалтыг 2017 оны 05 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, бог малын мялзан өвчний эрсдэл бүхий баруун болон төвийн бүсийн нийт 9 аймгийн мал эмнэлгийн мэргэжилтнүүд болон судалгаа, шинжилгээ, мал эмнэлгийн оношлогооны лабораторийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж мэдээлэл өгсөн		
11	Улсын нөөцөөс улаанбуудайн үр гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2016-05-02 №241	2. Улсын нөөцөөс иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой нөхцөлтэйгээр худалдсан улаанбуудайн үрийг нэр төрөл, тоо хэмжээгээр нь нөхөн бүрдүүлэхэд зохион байгуулалтын бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгасугай.	-ОБЕГ-ын улсын нөөцийн салбараас 2016 оны хаврын тариалалтад зориулан нийтдээ 660 тонн үрийн улаанбуудайг 50 хувийн урьдчилгаатайгаар, үлдэх хэсгийг намрын ургацаас нөхөн бүрдүүлэх гэрээтэйгээр 40 гаруй аж ахуйн нэгж, иргэнд олгож намрын ургацаас нөхөн бүрдүүлэв. -Үрийн буудайн үнийг буцаан төвлөрүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх, өр авлагыг бууруулах чиглэлээр улсын нөөцийн газарт мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллав. 2017 оны хаврын тариалалтад зориулан ОБЕГ-ын Улсын нөөцийн салбараас нийтдээ 70 аж ахуйн нэгжид 4.2 мянган тонн үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгов.		100
12	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-05-31 №287	2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран баталж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөв болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах, гадаад улс, олон улсын	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыгЗасгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолын дагуу ХХААХҮ-ийн сайд батлах болсон тул ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/54 дүгээр “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай” тушаал батлагдаж, гишүүдэд хүргүүлээд байна. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга		30

		байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Болор, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Эрүүл мэнд, спортын сайд С.Ламбаа нарт үүрэг болгосугай. 4.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Эрүүл мэнд, спортын сайд С.Ламбаа нарт үүрэг болгосугай.	хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан, уг төлөвлөгөөг батлах тухай хамтарсан тушаалын төслийн хамт ЭМ-ийн болон Сангийн сайд нарт хүргүүлээд байна. “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий үндэсний зөвлөл, түүний ажиллах журмыг ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А-54 дүгээр тушаалаар батлуулсан байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтот төслүүдэд санхүүжилт татах зорилгоор манай улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын байгууллагуудыг оролцуулсан хандивчлагчдын зөвлөлдөх уулзалтыг 2017 оны 9 дүгээр сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. ХХААХҮЯ-ны “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээний үеэр хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах талаар сурталчилгааны материал 1000 хувь хэвлүүлж, хэрэглэгчдэд тарааж сурталчлав		
13	Тогтоолын үйлчлэлийг түдгэлзүүлэх тухай /“Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт батлах тухай”/ 2016-09-14 №90	2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, дүнг 2017 оны 7 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт даалгасугай.	-Энэ тогтоолоор “Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт батлах тухай” Засгийн газрын 2013-08-20-ны өдрийн 300 дугаар тогтоолын үйлчлэлийг 2016-10-01-ний өдрөөс эхлэн 2017-08-01-ний өдрийг хүртэлх хугацаанд түр түдгэлзүүлсэн байна. -Тогтоол хэрэгжиж эхэлснээс хойш түүхий арьс, ширний үнэ тогтвортой өсөлттэй байна. 2016 оны эцэст 9118.8 мянган ам.доллар мөнгөн дүнтэй 489220 ш үхэр, адууны боловсруулаагүй шир, хуулдас экспортод гарсан нь өмнөх оныхоос тоо ширхэгийн хувьд 371470-аар буюу 4.2 дахин өсөж борлуулалтын дүнгээр 7319 мянган ам.доллараар илүү байв. Тэмээний түүхий шир энэ онд 3580 кг буюу 28.6 мянган ам.долларын борлуулалт хийгдсэн нь тогтоол гарсан үр дүн гэж үзэж байна. 2017 оны эхний 4 сарын байдлаар зах зээлийн ханшаар түүхий үхрийн шир 30-39.0 мянга болж 15 хувиар, адууны шир 26.0-35.0 мянга болж 27.0 хувиар, хонины нэхий 1.0-3.0 мянга болж 2 дахин, ямааны арьс 10.0-28.0 мянга болж 65.0 хувиар тус тус үнэ нь өссөн, харин 5 сард түүхий эдийн үнэ буурч үхрийн шир 21.0-28.0 мянга, адууны шир 16.0-20.0 мянга, хонины нэхий 2.0 мянган төгрөг байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад үнээ алдаагүй, харин хонины арьсны хувьд өнгөрсөн жилээс үнэтэй хэвээр байна. 2017 оны эхний 5 сарын байдлаар экспорт өмнөх оны мөн үетэй		30

			харьцуулахад үхэр, адууны боловсруулаагүй шир 346.2 мянга болж 2.9 дахин, борлуулалтын үнэ 6.8 сая ам.доллар болж 3.8 дахин өсчээ. Мөн үхэр, адууны боловсруулсан шир 41.7 сая дм2 болж 19.7 хувиар, үнийн дүн 4.8 сая ам.доллар болж 8.7 хувиар өссөн байна.		
14	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2016-10-26 №121	3. Төлөвлөгөөнд тусгасан томоохон төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэлийг 2017 онд багтаан эцэслэн боловсруулж 2018 оноос хэрэгжүүлж эхлэх бэлтгэлийг бүрэн хангаж ажиллахыг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ш.Дашдорж, Зам тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Нийслэлийн засаг дарга С.Батболд, Үндэсний хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярсайхан нарт даалгасугай.	Хөдөө аж ахуйн Халх гол бүтээн байгуулалтын бүсэд ургамал, мал эмнэлгийн хорио цээрийн дэглэм бүхий бүс байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулах ажил хийгдэж байна		30
15	Түр журам батлах тухай 2016-11-09 №138	2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар 2016 онд олгох 35.0 /гучин тав/ хүртэл тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулах ажлын энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан түр журмын дагуу яаралтай зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгасугай.	2016-12-07-ны өдөр төсөл сонгон шалгаруулах комиссын хуралдаанаар нийт 611 төсөл хэлэлцэгдэж 197 төслийг дэмжин санхүүжүүлэхээр шийдвэр гарсаны дагуу санхүүжүүлэх зорилгоор “Төсөлд дэмжлэг үзүүлэх тухай” ХХААХҮСайдын 2016-12-09-ний өдрийн А/62 тоот тушаал батлуулав. Дэмжигдсэн төслүүдээс 2016-12-27-ны өдрийн байдлаар 14 иргэн, ААН зээлийн гэрээ байгуулах шатанд, 44 иргэн, ААН-ийн санхүүжилтийг шийдвэрлэхэд бэлэн, 83 иргэн, ААН-ийн 39,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бүрэн шийдвэрлэж олгоод байна. Засгийн газрын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэржилтийг дэмжих зорилт, арга хэмжээний хүрээнд экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин, гарааны бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгож, нэмэгдүүлэх зорилгоор ЖДҮХ Сан 2016-11-11-23-ны өдрүүдэд иргэд, аж ахуйн нэгжүүдийн төслийг хүлээн авлаа. Энэ хугацаанд ЖДҮХСанд нийт 494,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн 704 иргэн, аж		70

			<p>ахуйн нэгжийн төсөл ирснээс зээл, төслийн ажлын хэсэг төсөл тус бүрийн зээлийн зарцуулалт, ажлын байр, дэвшилтэт технологи, суурь бааз, борлуулалтын орлого зарлага, зах зээлийн судалгаа хийсэн байдал, бүтээгдэхүүний зах зээлийн судалгааны үнэлгээ, борлуулалт зардлын төлөвлөлт, бэлэн мөнгөний урсгалын төлөвлөлт зэрэг үндсэн гол үзүүлэлтүүдээр үнэлгээ хийсэн. 2016 онд барилгын 14, био үйлдвэрлэлийн 2, боловсруулах үйлдвэрийн 1, газар тариалангийн 15, дахин боловсруулахын 2, зоорьны 7, мал аж ахуйн 22, өндөр технологийн 1, хөнгөн үйлдвэрийн 34, худалдаа үйлчилгээний 15, хүнсний 25, эмнэлгийн хэрэгслийн 1, нийт 138 төсөлд 59,6 тэр бум төгрөгийн зээл олгож 1901 ажлыг байр шинээр бий болж, 1268 ажлын байр хадгалагдсан.</p> <p>Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн журмыг ХХААХҮ-ийн сайд батлах болсонтой холбогдуулан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн журам”-ын төслийг боловсруулан яамны вэбсайтад байрлуулан олон нийтээр хэлэлцүүлж байна. Мөн 2017.05.04 өдөр жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 63 хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлгийг зохион байгуулж гарсан саналуудыг төсөлд тусган ажиллаж байна. Журам батлагдсанаар хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт олгогдоно.</p>		
16	<p>Хөдөө аж ахуйн “Халх гол” бүтээн байгуулалтын бүсийн талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2016-12-14 №187</p>	<p>1. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийг хөгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд ээлтэй, экспортын баримжаатай мал аж ахуйн болон газар тариалангийн эрчимжсэн аж ахуй, үйлдвэр байгуулах, дэд бүтэц, аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, арга хэмжээг дотоод, гадаадын хөрөнгө оруулагч, хандивлагч байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж ажиллахыг</p>	<p>Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийг хөгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэлэлцүүлэгт бэлтгэж байна.</p>		30

		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд үүрэг болгосугай.			
		2. Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журмыг зөрчин “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны өмнөх удирдлагаас газар олгосон шийдвэрүүдийг хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгасугай.	Хөдөө аж ахуйн “Халх гол” бүтээн байгуулалтын бүсийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2016 оны 187 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХААХҮ-ийн Сайдын 2016 оны А-76 дугаар тушаалаар хууль тогтоомжид нийцсэн арга хэмжээ авч ажиллах, хэрэгжүүлсэн талаарх тайланг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Хөдөө аж ахуйн “Халх гол” бүтээн байгуулалтын бүсийн захиргаанд даалгасан. Үүний дагуу Бүсийн захиргааны захирлын 2017 оны 1 дүгээр сарын 10-ний өдрийн А-01 тушаалаар Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журмыг зөрчин “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны өмнөх удирдлагаас газар олгосон шийдвэрүүдийг хүчингүй болгосон.		100
17	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-12-21 №193	6. Төрийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх, татан буулгах үйл ажиллагааг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдэн хамтран зохион байгуулж, өмчийн бүртгэлд тусгуулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Аж үйлдвэрийн яамнаас шилжиж ирсэн 833,102,320.47 төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 10-р сарын 27-ний өдрийн 125 дугаар тогтоол гаргуулан яамны балансад холбогдох хууль журмын дагуу бүртгэж авав.		100
18	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2017-01-04 № 06	4. Олон улсын гэрээ, конвенцид заасан болон олон улсын байгууллагаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, арга хэмжээнээс бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулах олон улсын хурал, зөвлөгөөнийг жил бүрийн 9 дүгээр сараас дараа оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд зохион	Баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, шим тэжээлийн дутлаас сэргийлэхэд чиглэсэн Төв Евроазийн орнуудын чуулганыг 2017 заасан хугацаанд УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо , Байгаль орчин хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эрүүл мэнд, спортын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулж, хүн амын хоол, шим тэжээл, баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийн талаарх туршлагын талаар 3 өдрийн хуралдааныг зохион байгуулж, санал солилцов.		100

		байгуулж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.		
19	Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-01-11 № 14	1. Өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан орон нутгаас мал, мах бэлтгэх ажлыг мах боловсруулах үйлдвэр, зориулалтын зоорь бүхий аж ахуйн нэгжүүдтэй хамтран шуурхай зохион байгуулах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгасугай.	<p>Өвөлжилт хүндэрсэн 17 аймгийн 126 сумын малчин болон мал бүхий иргэдээс мал, мах бэлтгэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд мах боловсруулах үйлдвэр, зориулалтын зоорь бүхий 9 аж ахуйн нэгжтэй нийт 12.9 мянган тн мах бэлтгэх гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тогтоолоор өвөлжилт хүндэрч байгаа орон нутгаас мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг мах боловсруулах үйлдвэрүүд, мах хадгалах зориулалтын агуулах бүхий аж ахуйн нэгжүүдтэй хамтран шуурхай хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн банкнаас “Мах” хөтөлбөрт оролцогч 6 компанид нийт 13.2 тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгосон. Тухайлбал: Голомт банкаар дамжуулан Сүхбаатар мах маркет ХХК-д 2.1 тэрбум төг, Эй Эн Ди Эм ХХК-д 2.1 тэрбум төг, Мах импэкс ХК-д 3.8 тэрбум төг, ХААН банкаар дамжуулан Эрдмийт ХХК-д 2.5 тэрбум төг, Сайнза интернэшнл ХХК-д 603.6 сая төг, ХХБ-аар дамжуулан ХКҮ ХХК-д 2.1 тэрбум төг-ийн зээлийг олгосон байна.</p> <p>Хөгжлийн банкаас дээрх 6 компанид арилжааны банкаар дамжуулан нийт 13.2 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд зээлийн жилийн хүүний 8 хувийн хөнгөлөлтийн зардлыг тус яамнаас санхүүжүүлэхээр Хөгжлийн банктай гэрээ байгуулсан.</p> <p>Арилжааны банкуудаас Худалдаа хөгжлийн банк, Хаан банк, Төрийн банк уг арга хэмжээнд оролцохоор саналаа ирүүлснээс арилжааны банкны зээлийн хорооны шийдвэр нийт 4 аж ахуйн нэгжид гарсан. Хаан банкнаас 5 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр гарсан “Завхан хүнс групп” ХХК нь уг зээлийг авахаас татгалзаж буй тухай хүсэлтээ гаргасан. Төрийн банкны хувьд ямар ч аж ахуйн нэгж дээр зээлийн хорооны шийдвэр гаргаж ирүүлээгүй.</p> <p>Худалдаа хөгжлийн банкаас зээл олгохоор шийдвэрлэсэн 3 аж ахуйн нэгжийн Дархан мийт фүүдс ХХК-д 30.0 тэрбум төгрөг, Дельта хольдинг ХХК-д 8.0 тэрбум төгрөг, Хүнс комплекс ХХК-д 400 сая төгрөгийн буюу нийт 38.4 тэрбум төгрөгийн зээлийн жилийн хүүний 10 хувийн хөнгөлөлтийн зардлыг тус яамнаас санхүүжүүлэхээр Худалдаа хөгжлийн банктай гэрээ байгуулсан.</p>	100

			Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 9 үйлдвэр, мах хадгалах зориулалтын зоорь бүхий аж ахуйн нэгжид зээлийн хүүний хөнгөлөлтийн дэмжлэг үзүүлж, өвөлжилт хүндэрсэн орон нутгаас 12.9 мянган тонн, мөн “Мах” хөтөлбөрийн хүрээнд 2016 онд зээл нь олгогдсон 4 аж ахуйн нэгж 2.9 мянган тонн, нийт 15.8 мянган тонн махыг бэлтгэсэн. 2017 оны 4 дүгээр сараас эхлэн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд тогтоосон үнээр буюу зах зээл дэх махны үнээс 10-30 хувь хямд үнээр хэрэглэгчдэд нийлүүлж эхэлснээр махны үнийг тогтворжуулж, хаврын улиралд махны хомсдол үүсэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн. 2017 оны 6 дугаар сарын байдлаар нийт бэлтгэсэн махны 72 хувь буюу 11.3 мянган тонн махыг худалдан борлуулаад байна.		
		2. Мал, мах бэлтгэхэд зориулан мах боловсруулах үйлдвэр, зориулалтын зоорь бүхий аж ахуйн нэгжүүдэд Хөгжлийн банк болон арилжааны банкнаас олгосон зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай.	Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн банкаас “Мах” хөтөлбөрт оролцогч 6 аж ахуйн нэгжид нийт 13.2 тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгосон бөгөөд зээлийн жилийн хүүгийн 8 хувийн хөнгөлөлтийн зардлыг, мөн арилжааны банкнаас олгосон 38.4 тэрбум төгрөгийн зээлийн жилийн хүүгийн 10 хувийн хөнгөлөлтийн зардлыг ХХААХҮ-ийн сайдын 2017 оны төсөвт тусгагдсан салбарын урамшууллын зардлаас тус тус санхүүжүүлэх гэрээг байгуулсан.		100
20	Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай 2017.01.25 № 27	3. Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах энэ тогтоолын 20 дугаар хавсралтаар баталсан орон тооны бус комисс, хороо, зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг холбогдох Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн, Засгийн газрын агентлагийн даргатай тохиролцсоны үндсэн дээр шинэчлэн баталж ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд шуурхай зохион байгуулах шаардлагын улмаас Улсын ургацын комиссын бүрэлдэхүүний ХХААХҮ-ийн Сайдын 2016 оны 08-р сарын 16-ны өдрийн А-03 тушаалаар шинэчлэн байгуулав.		70
		4. Хууль тогтоомжид заасан байнгын үйл ажиллагаатай, орон	Хууль тогтоомжид заасан байнгын үйл ажиллагаатай, орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсэг байгуулаагүй		100

		тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсэг байгуулахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	байна.		
21	Зарим компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болон олгох тухай 2017.02.01 № 41	3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Татварын ерөнхий газрын дарга Л.Зориг нарт тус тус үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор Дорнод аймгийн “БД” ХХК, “Анчир” ХХК-ийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүйболгосны дагуу тухайн аймгийн МХГ, ХХААГ, ЗДТГ-т болон МХЕГ, ТЕГ-т мэдэгдэж, хяналт тавин ажилласан. Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, аж ахуйн нэгжийн өөрийн хүсэлтийг харгалзан “Хөхтэнгэр хөвсгөл”ХХК-ийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийгхүчингүй болгож, “Хөх тэнгэр хөвсгөл” ХХК-ийн хувьцааны 51 хувийг худалдаж авсан “Хөвсгөл хүнс”ХК-д Хөвсгөл аймгийн Мөрөн суманд хүнсний спиртээр жилд 160 тн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгосоны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 1/337 дугаар албан бичиг, Хөвсгөл аймгийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 23-02-003/62, 2013 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 23-03-018/447, 2010 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 50-77/421 дүгээр дүгнэлт, Татварын ерөнхий газрын 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 01/522, Үндэсний татварын албаны 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1702150307472 дугаар тодорхойлолт, Хөвсгөл аймгийн татварын хэлтсийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 76 дугаар тодорхойлолтыг тус тус харгалзан “Хөвсгөл хүнс” ХК-д архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 02 дугаар сараас эхлэн 3 жилийн хугацаатай олгож, хяналт тавин ажиллаж байна. Засгийн газрын 2008 оны 4 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу тусгай зөвшөөрөл нэмж олгоогүй бөгөөд Засгийн газрын тогтоолоор 2012 оноос хойш архины 43, спиртийн 6, дарсны 5, пивоны 7, нийт 61 компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Үүний үр дүнд архины үйлдвэрийн тоо 2012 онд 75 байсан бөгөөд одоогийн байдлаар 48 болж 40-өөд хувиар буурсан. Говьсүмбэр, Хэнтий, Орхон, Сүхбаатар, Дорноговь аймаг архины үйлдвэргүй байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр нэг хүнд ногдох бүртгэгдсэн согтууруулах ундааны хэрэглээг архи,		100

			дарсанд шилжүүлж тооцоход 2012 онд 10,8 литр байсан бол 2015 онд 7.2 литр болж буурсан.		
22	Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2017.02.01 № 46	1. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, үйлдвэрлэлд хяналт тавих журам, Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалтад хяналт тавих журмыг Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нийцүүлэн шинэчлэн баталж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг шинэчлэн тогтоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 46 дугаар тогтоолоор даалгасны дагуу ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А-19 дүгээр тушаалаар “Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын төсөл болон Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих, Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журмыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулан журмын төсөл, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулгыг боловсруулж, ажлын хэсгийн гишүүдээс санал авч байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ХЗДХЯ, ЭМЯ, СЯ, МХЕГ, ГЕГ, НХХААГ, ТББ-аас төлөөлөл оролцсон. Журмын төсөлд 2013 оноос хэрэгжсэн Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудад нийцүүлэн согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчид тавих хяналтыг нарийвчлан тусгасан: - Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахыг хүссэн өргөдлийг энэ журмын хавсралт маягтын дагуу хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад гаргана. -Хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь согтууруулах ундааны үйлдвэрийн үйл ажиллагааны тухай дүгнэлт, саналыг мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан байгууллагаас, татвар төлөлтийн талаарх санал, тодорхойлолтыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тус тус авна. -Журмын 5.4-т заасан дүгнэлт, тодорхойлолтод тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнг хавсаргана. -Журмын 5.4-т заасан дүгнэлтэд тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа хэтэрсэн бол үйлдвэрлэл эрхэлсэн эсэх болон тусгай зөвшөөрлийг сунгаж эхлэх хугацааг тусгах бөгөөд согтууруулах ундааны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудасны хуулбарын хамт хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. -Хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг авахаар согтууруулах		30

		<p>ундааны үйлдвэрийн үйл ажиллагааны тухай мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан байгууллагын дүгнэлт, санал, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын татвар төлөлтийн талаарх санал, тодорхойлолт, цагдаагийн байгууллагын саналыг тус тус хавсарган хүргүүлнэ.</p> <p>-Хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах шаардлагатай аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг хагас жил тутам гаргаж, журмын 5.4, 5.7 дахь заалтад заасан дүгнэлт, саналыг холбогдох байгууллагуудаас авч болно.</p> <p>Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 46 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 5 сарын 05-ны өдрийн А-62 дугаар тушаалаар “Архи согтууруулдах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаархи нормативыг тогтоох” ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.</p>		
		<p>2. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа байдалд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газартай хамтран 2017 онд багтаан улсын хэмжээнд хяналт шалгалт хийж дүнг Засгийн газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгасугай.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 46 дугаар тогтоолоор даалгасны дагуу МХЕГ, ТЕГ-тай хамтран улсын хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд холбогдох хуульд заасан нийтлэг эрх, үүргийн хүрээнд тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, өмнөх онуудад үйлдсэн албан шаардлага, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, эрсдлийн үнэлгээнд тулгуурлан эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагчийн дүгнэлт, санал гаргах, хяналт шалгалтын дүнг Засгийн газарт танилцуулахаар удирдамж боловсруулан баталж, ажлын хэсгүүдийг томилон, улсын хэмжээнд хяналт шалгалт хийсэн. Хяналт, шалгалтад Ховд, Дорнод, Өмнөговь, Увс, Баян-Өлгий, Дундговь, Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Төв, Улаанбаатар зэрэг аймаг, хотын согтууруулах ундааны үйлдвэрүүдийг хамруулсан.Хяналт шалгалтын дүнг энэ оны 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулахаар ажиллаж байна.</p>	30
23	Хөтөлбөр батлах тухай 2017-03-20	3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж	Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажилын хүрээнд ХХААХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 02 сарын 10-ны А-22 тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	0

	№98	ажиллахыг “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.			
24	Журам батлах тухай /“Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”/ 2017-04-12 №111	2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн заавар, аргачлалаар хангаж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад, журмыг эрхлэх ажлынхаа хүрээнд үе шаттайгаар нэвтрүүлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2017 оны хагас жилийн байдлаар ХХААХҮЯаманд ирсэн 4453, явсан 2025 харилцан бичгийн албан бичиг нь цахим хувь үйлдэж архивлагдсан байна, мөн 420 тушаал хавсралтуудын хамт, байнгад хадгалагдах баримтууд цахим хувь давхар үйлдэж архивлагдаж байна.		100
25	Ажлын хэсэг байгуулах тухай 2017-05-24 №150	2. "Монгол-Хятадын Экспо" арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсвийг тухай бүр батлуулан бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газарт танилцуулж ажиллахыг Ажлын хэсэгт, уг арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан эрхэлсэн ажлынхаа хүрээнд хамаарах асуудалд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.	2017 оны 4 дүгээр улиралд БНХАУ-ын ӨМӨЗО-ын Хөх хотод “Монгол Хятадын экспо” хоёр дахь удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар ХХААХҮЯамны ТНБД-аар ахлуулсан ХХААХҮ-ийн Сайдын 2016-12-22-ны өдрийн А-78 дугаар тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсэг 2017-03-23-ны өдөр Хятадын талын төлөөлөгчдийг хүлээн авч ажил хэргийн уулзалтыг зохион байгууллаа. Мөн айлын талын ажлын хэсгээс ирүүлсэн хөтөлбөрийн төслийг бүх яамд болон агентлагуудаас санал авч нэгтгэв. Мөн цаашид экспоны арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулах, эрчимжүүлэх зорилгоор 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлж ХХААХҮ-ийн Сайд П.Сэргэлэнгээр ахлуулсан байнгын ажлын хэсгийг 7-р сард хуралдуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		30
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ					
1	2014 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр 59 дүгээр	II.2. “Биокомбинат” ТӨААТҮГ-ыг шинэчлэхэд Унгар Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл авах эсэх асуудлыг ойрын хугацаанд	-Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хооронд Биокомбинат ТӨҮГ-ын иж бүрэн шинэчлэлийн төслийг санхүүжүүлэх зорилго бүхий “Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн хэлэлцээр”-ийг 2016 оны 01 дүгээр сарын 25-ны		70

	<p>тэмдэглэл /ТЗУГ, ГХАХ/</p>	<p>эцэслэн шийдвэрлүүлэхийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын үүрэг гүйцэтгэгч Ш.Түвдэндоржид даалгав.</p>	<p>өдөр байгуулсан. -Хэлэлцээрийн хүрээнд Биокомбинат ТӨҮГ-ын иж бүрэн шинэчлэлийг Унгарын Засгийн газрын 25 сая ам.долларын нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэхээр болсон. Дээрх төслийг хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А-45 тушаалаар ажлын хэсгийг байгуулав. Тус ажлын хэсэг нь биокомбинатыг иж бүрэн шинэчлэх ажлын даалгаварыг боловсруулан, хэлэлцэж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/1353 тоот албан бичгээр Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газарт хүргүүлэв. -Монголын талын Ажлын хэсэг байгуулагдан төслийн ажлын даалгаврыг боловсруулан айлын талд хүргүүлсэн ба үүний дагуу 2017 оны 01 дүгээр сард Унгар улсын Гадаад хэрэг, худалдааны яамны Улс төрийн зөвлөх Балинт Томбороор ахлуулсан экспэртүүд Монгол Улсад хүрэлцэн ирж Техникийн түвшний уулзалтыг зохион байгуулан протокол үйлдсэн бөгөөд шинэчлэлийн ажлын төлөвлөгөө, хугацааг харилцан тохиролцсон. Үүний дагуу Унгар Улсаас техникийн шинжээч, мэргэжилтнүүдийн баг 3-р сарын 30-ны өдөр Монгол Улсад ирж ажилласан байна. Талууд Биокомбинат ТӨҮГ-ын хуучин барилгыг шинэчлэх эсвэл шинээр барилга барин шинэчлэх асуудлыг эцсийн байдлаар шийдвэрлэхээр тохиролцох шатандаа явж байгаа болно.</p>		
2	<p>2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 63 дугаар тэмдэглэл /ТЗУГ, ГХАХ/</p>	<p>IX.3.Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах талаар Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2013 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” 01/01 дүгээр</p>	<p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2013 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” 01/01 дүгээр зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p>		100

		зөвлөмжийг Засгийн газрын гишүүдэд тарааж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг даалгав.			
3	2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр 1 дүгээр тэмдэглэл	ХИ.4 Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар Хууль зүйн сайд Д.Дорлигжав Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав:	Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийг мөрдөж, захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулахдаа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдээс саналыг авах арга хэмжээ авч ажиллах асуудлыг ХХААХҮЯ-ны “Албан хэрэг хөтлөлтийн журам-д тусган ажиллаж байна. Мөн шийдвэрийн төсөлд яамны цахим хуудсаар дамжуулан санал авах, мэргэжлийн байгууллага, мэргэжилтнийг ороцуулсан нээлттэй хэлэлцүүлэг хийх арга хэлбэрийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам” хүчингүй болсон.	Хүчингүй болсон тул хяналтаас хасах	70
		4.1. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл боловсруулахдаа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийн саналыг авч, шаардлагатай бол саналыг тусгах арга хэмжээ авах;	4.2. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын хэрэгжилтэд 2017 онд хийх хяналт-шинжилгээг 3 дугаар улиралд хийхээр төлөвлөсөн. Салбарын хуулиудад захиргааны хэм хэмжээний акт батлахаар Сайдад тусгайлсан эрх олгосон заалтуудыг судлан жагсаалтыг гаргасан.		ХБ
		4.2. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцож байх;	4.3. 2010 онд батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нийцүүлэх зорилгоор Малын эмийн зөвлөлийн ажиллах журам, Малын эм бүртгэлийн дүрэм, Мал эмнэлгийн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт баталсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 261 дүгээр тушаалыг хүчингүй болгон, 2017 оны А-49, А-50 дугаар тушаалуудаар шинэчлэн баталж, улсын нэгдсэн бүртгэлийн 3723, 3724 дугаарт бүртгүүлсэн. 2017 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоох тухай Сайдын 2017 оны А-23 дугаар тушаалыг батлуулан улсын нэгдсэн бүртгэлийн 3699 дугаарт бүртгүүлсэн. 2017 онд хөдөө аж ахуйн ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээ, Газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох химийн бордооны жагсаалт, хэрэглэх хэмжээг БОАЖС, ХХААХҮС, ЭМС-ын 2017 оны А/30, А-20, А/62 дугаартай хамтарсан тушаалаар баталж, улсын нэгдсэн бүртгэлийн 3702 дугаарт бүртгүүлсэн.		30
		4.3. Шинээр гарсан хууль тогтоомжид нийцүүлэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж байх; 4.4. хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ	2017 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоох тухай Сайдын 2017 оны А-23 дугаар тушаалыг батлуулан улсын нэгдсэн бүртгэлийн 3699 дугаарт бүртгүүлсэн. 2017 онд хөдөө аж ахуйн ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээ, Газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох химийн бордооны жагсаалт, хэрэглэх хэмжээг БОАЖС, ХХААХҮС, ЭМС-ын 2017 оны А/30, А-20, А/62 дугаартай хамтарсан тушаалаар баталж, улсын нэгдсэн бүртгэлийн 3702 дугаарт бүртгүүлсэн. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ыг Сайдын 2017 оны А-76		

		тогтоосон шийдвэр гаргахгүй байх	дугаар тушаалаар баталж, бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. 2016 онд батлагдсан Органик хүнсний тухай хуулиар тусгайлан эрх олгосон заалтуудын дагуу захиргааны хэм хэмжээний актуудыг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг боловсруулж байна.		
			4.4. Хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаагүй болно.		100
4	2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр 05 дугаар тэмдэглэл	ХИҮ.2. Хүнсний улаан буудайн тариалалтыг дэмжих зорилгоор экспортод гаргах рапст ногдуулах гаалийн албан татварт улирлын чанартай зохицуулалт хийх асуудлыг судалж, санал боловсруулан Засгийн газарт оруулахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгав.	Судалгаа хийгдэж байна.		0
5	2015 оны 06 дугаар сарын 04-ны өдөр 33 дугаар тэмдэглэл	Ш.Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийг бордоо, ургамал хамгааллын бодис, техник, технологийн шинэчлэлд ашиглах, мал, мах, хөдөө аж ахуйн гаралтай бусад бүтээгдэхүүний экспортыг тухайн импортлогч улсуудын хорио цээрийн байгууллагуудтай харилцан тохиролцож шийдвэрлэх, малчны лавлах шуурхай утсыг ажиллуулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	-Ш.Тариалангийн тухай хуулийн төслийг боловсруулж, ЗГ-аар хэлэлцүүлэн, УИХ-ын Байгаль орчин хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороотой хамтран УИХ-аар хэлэлцүүлж 2016 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр батлуулан, мөрдөж эхэлсэн. -ОХУ-ын бүх нутаг дэвсгэрт адууны мах, адууны дайвар бүтээгдэхүүн, адууны өөх тос нийлүүлэх, тус улсын өмнөд мужууд дахь боловсруулах үйлдвэрүүдэд ястай үхрийн мах, үхэр, хонь, ямааны ясгүй мах болон үхрийн дайвар бүтээгдэхүүн, үхрийн өөх тосыг, нийлүүлэх боломжтой болсон. -БНХАУ болон Монгол Улсын баруун 5 аймагт тавьсан шүлхийн хоригийг цуцалсан бөгөөд тус улстай хамтран дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох хүнсний аюулгүй байдлын хамтын ажиллагааны санамж бичиг, адууны махан бууз, банш экспортлох тухай санамж бичиг, адууны ясны гурил экспортлох үеийн мал эмнэлэг, хорио цээрийн тухай протоколд гарын үсэг зурсан. Харин хонь, ямаа, үхрийн мах экспортлохтой холбогдсон хяналт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протокол болон мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээний загварт		100

			<p>гарын үсэг зурахаар бэлтгэл хангаж байна.</p> <p>-Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас га-ийн ургацыг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор Япон Улсын хүнсний тусламжийн хөрөнгөөр “Нийлмэл бордоо” нийлүүлэх ТШ-КР1-2015/БН-01 дугаар бүхий бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж байна. Энэхүү ажлыг зохион байгуулснаар газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэд хөнгөлөлттэй нөхцөлөөр бордоо авах боломжтой болно.</p>		
6	2015 оны 07 дугаар сарын 20-ны өдөр 43 дугаар тэмдэглэл	ХХҮ.1. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, удаашралтай болон тасарч байгаа заалтын биелэлтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Худалдааны салбарыг бодлогын шинэ түвшинд гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-46 дугаар тушаалаар “Худалдааны тухай”, “Дэмпингийн тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. 2017-01-18-ны өдөр хуулийн төслийн ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан бөгөөд 2017-01-01-ний өдрөөс хэрэгжиж буй “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор МҮХАҮТ-тай хамтран 21 амаг болон нийслэлийн хэмжээнд 3100 хүнээс тандан судалгааг авч нэгтгэн ажлын хэсэгт танилцуулаад байна.		100
7	2016 оны 02 дугаар сарын 22-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл	XIV. “Монгол орны хөрс, цаг уурын нөхцөлд тохирсон эрт болцтой, өвчин, ганд тэсвэртэй, арвин ургацтай үр тарианы сорт гаргах, нутагшсан сортын үр үйлдвэрлэл” хөтөлбөрийг Оросын Холбооны Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх тухай Хүнс, хөдөө аж ахуйн яамны саналыг хэлэлцэн дэмжээд, уг саналыг холбогдох баримт бичгийн хамт оросын талд албан ёсоор хүргүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн нарт даалгав.	<p>-“Монголын цаг уурын нөхцөлд тохирсон, эрт болцтой, өвчин, ганд тэсвэртэй үр тарианы сорт гаргах, нутагшуулах хамтарсан хөтөлбөр”-ийг ОХУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>-Засгийн газрын 02 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр тэмдэглэлийн дагуу Гадаад хэргийн яамнаас 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн К/16-472 тоот ноот бичгээр дээрх хөтөлбөрийг ОХУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Оросын талд хүргүүлэв.</p> <p>-Мөн дээрх асуудлыг Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 20 дугаар хуралдааны тэмдэглэлд дахин тусгуулсан болно. Улсын сорт сорилтын зөвлөлийн хурлаар тэжээлийн вандуйн И2964 сортыг нутагшсан сортоор батлуулж зусах зөөлөн буудайн Тризо сортыг сорилтод оруулахаар тус тус шийдвэрлэв.</p>		70
8	2016 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 18 дугаар	XIX.3. “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгасан зорилт, арга хэмжээг 2015 онд хэрэгжүүлсэн	Тайлагнах хугацаа болоогүй.		ХБ

	тэмдэглэл	явцын тухай “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.			
9	2016 оны 03 дугаар сарын 28-ний өдөр 18 дугаар тэмдэглэл	Дотоодын үйлдвэрлэлийг гадаад худалдаанаас учирч болох хохирлоос хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд үзэл баримтлалыг Хууль зүйн сайдтай хамтран баталж, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан хуулийн төслийн нэрийг оновчтой болгох зэрэг саналыг тусган хуулийн төслийг боловсруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав.	Худалдааны салбарыг бодлогын шинэ түвшинд гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-46 дугаар тушаалаар “Худалдааны тухай”, “Дэмпингийн тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. 2017-01-18-ны өдөр хуулийн төслийн ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан бөгөөд 2017-01-01-ний өдрөөс хэрэгжиж буй “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор МҮХАҮТ-тай хамтран одоогийн байдлаар 2000 орчим тандан судалгааг авч нэгтгээд байна.		30
10	2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр 20 дугаар тэмдэглэл	XXIII.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны худалдан авах ажиллагааны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнг Сангийн сайд Б.Болор Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 1. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, цаашид худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журам, зааврын дагуу хэрэгжүүлэх, 2015 оны үнэлгээгээр хангалтгүй дүн авсан албан тушаалтанд хариуцлага тооцож,	1. “Худалдан авах ажиллагааны 2015 оны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн” Сангийн сайдын 2016.03.31-ний өдрийн 5/1859 тоотой ирүүлсэн албан бичгийн мэдээлэл нь зөрүүтэй байгаагаас Хүнс, хөдөө аж ахуйн сайдын багцын 2015 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээг дахин нягтлан үзэх тухай 2016 оны 01/1295 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн. “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд худалдан авах ажиллагааны улирлын тайланг нэгтгэн цаг хугацаанд нь хүргүүлж байна. Хүнс,хөдөө аж ахуйн салбарын 2016 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 1 дүгээр улирлын явцын тайланг 2016 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 01/1086 тоот албан бичгээр хүргүүлсэн. 1.Хүнс,хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2016 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тайланг 2017 оны 1 дүгээр	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хяналтаас хасах	100

		<p>дүнг 2016 оны 4 дүгээр сард багтаан Сангийн яаманд танилцуулах;</p> <p>2. “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, худалдан авах ажиллагааны улирлын тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж байх;</p> <p>3. Монгол Улсын төсвийн тухай хуулиар баталсан урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийг 2016 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор зарлан, мөн оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор тендер шалгаруулалтыг зохион байгуулж дуусган, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн байх;</p> <p>4. Тендер шалгаруулалтын урилгыг олон нийтэд зарлан мэдээлэхдээ оролцогч аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлэн ажиллах.</p>	<p>сарын 13-ны өдрийн 01/173 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2.ХХАА-н салбарын 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сайдын 2015 оны А-165 дугаар тушаалж нийт 32 худалдан авах ажиллагаанаас 32 тендерийг зарласан бөгөөд Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор 30 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.</p> <p>3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн бичиг баримтанд аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах тухай тусган ажиллаж байна.</p> <p>4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,үйлчилгээ үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн бичиг баримтанд аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах тухай тусган ажиллаж байна.</p>		<p>100</p> <p>70</p> <p>70</p>
11	2016 оны 05 дугаар сарын 2-ны өдөр 25 дугаар тэмдэглэл	XVI. Хүнс, хөдөө аж ахуйн яам, Мал эмнэлэг, үржлийн газраас мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулсан “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Хонь,	Малэмнэлэг, үржлийн газраас мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулсан “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ын төслүүдийг ХХААЯ-ны сайдын зөвлөлөөр хэлэлцүүлсэн хэдий ч Захиргааны хариуцлагын ерөнхий хууль үйлчилж эхэлсэнтэй холбоотойгоор батлуулах ажил хойшилсон болно. Стратегийн баримт бичгийн төсөлд “Хонь, ямааны цэцэг		70

		ямааны цэцэг өвчинтэй тэмцэх заавар”-ын төслүүдийг хэлэлцээд холбогдох хууль тогтоомжийн дагуу батлан мөрдүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	өвчнийг хяналтад авахад шуурхай туслалцаа үзүүлэх нь” ТСР/MON/3603 төслийн хүрээнд 2017 оны 06 дугаар 14-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан бүсийн уулзалтын үеэр Монгол Улсад ажилласан олон улсын зөвлөхүүдийн санал, зөвлөмжийг тусгах хэлэлцүүлгийг ажлын хэсгээр хийхээр төлөвлөөд байна.		
12	2016 оны 5 дугаар сарын 23-ны өдөр 29 дүгээр тэмдэглэл	XVII. Бэлчээрийг хамгаалах хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцээд үзэл баримтлалын төслийг Хууль зүй болон Сангийн сайдтай хамтран баталж, Газрын тухай хууль, холбогдох хуультай уялдуулан давхардал, зөрчил гаргахгүйгээр боловсруулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Бэлчээрийг хамгаалах хуулийн төслийг УИХ-ын гишүүд санаачлан боловсруулахаар байсан боловч “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн төсөлд 7 хуулийг Засгийн газарт боловсруулах чиглэл өгсөн үүргийн дагуу дээрх хуулийг боловсруулах хүрээнд бэлтгэх ажил хийгдэж байна.		0
13	2016 оны 08 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл	XI.1.4 Үндэсний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх талаар санал боловсруулж 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах, төрийн байгууллагуудын төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтад үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийг иргэддээ уриалахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт;	1. "Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай зарим арга хэмжээний талаар авах арга хэмжээ"-ний талаар Засгийн газарт 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулга хийсэн. Үүний үр дүнд ЗГ -ын 48 дугаар тэмдэглэл гарч "Нийт иргэд аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдэд үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийг уриалж, худалдан авалт хийсэн байгууллагыг урамшуулах, худалдан авах ажиллагааг дэмжсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажиллах"-ыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосон шийдвэр гарсан. 2 а/ “ЗГ-ын 100 хоног” “Эрүүл хүнс- Эрүүл Монгол хүн, -Үндэсний үйлдвэрлэл” уриан дор 200 гаруй үндэсний үйлдвэрлэгчдийг оролцуулан үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгуулж, 1 тэрбум төгрөгний борлуулалт хийж, дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийг уриалж, төрийн худалдан авалтыг дэмжих үйл ажиллагаа, сурталчилгаа явуулсан. б/ Ноос, ноолуур, хэвлэл, арьс шир-2016” үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг 2016 оны 10-р сарын 20-24 ны өдрүүдэд Мишээл экпо үзэсгэлэнгийн танхимд Арьс шир, ноос ноолуур, хэвлэлийн холбоод хамтран зохион байгууллаа.Уг арга хэмжээний хүрээнд нийт 156 аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид 531 сая төгрөгийн борлуулалт хийж, загварын шоу зохион байгуулж,		70

			<p>шилдэгийн шилдэг бүтээгдэхүүн, үйлдвэрлэгчид, нэр төрлийг шалгаруулав.</p> <p>3/ Нийт иргэд аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдэд үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийг уриалж, 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн.</p> <p>4. 2015 оны тайланд төсвийн 30 байгууллагын 60,6 тэрбум төгрөгийн худалдан авалтаар дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн авсан ба худалдан авалтад давхардсан тоогоор 459 аж ахуйн нэгж байгууллага оролцсон бол 2016 онд төрийн болон төрийн өмчийн 63 байгууллага төсвийн хөрөнгөөр хийсэн худалдан авалтад давхардсан тоогоор 2608 аж ахуйн нэгж байгууллагаас 193,7 тэрбум төгрөгийн бараа, бүтээгдэхүүн нийлүүлсэн байна.</p> <p>Эдгээр худалдан авсан бүтээгдэхүүний 76% буюу 147,5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн, 24% нь ажил үйлчилгээ болон импортын бараа бүтээгдэхүүн /шатахуун, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж/ худалдан авсан байна.</p> <p>Дотоодын үйлдвэрээс хийсэн худалдан авалтыг өнгөрсөн оны мөн дүнтэй харьцуулбал 2.4 дахин өссөн байна.</p>		
14	2016 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 43 дугаар тэмдэглэл	<p>IX.3.1 Малын гоц халдварт шүлхий өвчин болон цэцэг өвчний гаралт, тархалтын өнөөгийн байдлыг яаралтай судалж холбогдох хууль тогтоомжийн дагуу авах арга хэмжээний санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд яаралтай оруулахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт даалгав.</p>	<p>Засгийн газрын хуралдаанд Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний санал боловсруулан танилцуулж, 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 71 дүгээр тогтоолыг гаргаж, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p>	100	
		<p>IX.3.3 Мал сүргээ эрүүлжүүлэх талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулан шийдвэрлэх арга хэмжээ авч, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх стратегийг шинэчлэн батлахыг Хүнс, хөдөө аж ахуй,</p>	<p>-“Мал эмнэлгийн хяналтын цэгт хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулан 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд тус хуралдааны 25 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А-102 тоот тушаалаар журмыг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>- Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх стратеги, төлөвлөгөө, зааврыг</p>	30	

		хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, бодлого, стратегийг хэрэгжүүлэх хөрөнгийг 2017 оны улсын төсөвт тусгахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгав.	боловсруулан 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд тус хуралдааны 25 дугаар тэмдэглэлээр дэмжигдсэн. Засгийн газрын гишүүдийн саналыг тусган нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор Малэмнэлэг, үржлийн газрындаргын 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар ажлыг хэсэг байгуулж, “Мал, амьтны гоц халдварт өвчний бэлэн байдлын төлөвлөгөө”, “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх стратеги 2018-2023”-ийг боловсруулан хэлэлцүүлэг зохион байгуулж байна.		
		Х. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн үзэл баримтлалын төслийг хэлэлцээд зохих журмын дагуу хянан баталж, хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт нарт даалгав.	Хуулийн үзэл баримтлалын төслийг ХЗДХЯ-аар хянуулж, 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын дагуу томилогдсон ажлын хэсэг хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын 2016.12.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, мөн өдрийн 61 дүгээр тэмдэглэлээр УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Улмаар 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг, 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг тус тус хийсэн. БОХАА-н байнгын хороо тус хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж байна.	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай байна.	100
15	2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 48 дугаар тэмдэглэл	ХҮП.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов.	Тэмдэглэлд тусгагдсан үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран ажиллах “САНАМЖ БИЧИГ”-ийг байгуулав. Санамж бичгийн хүрээнд “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2017” өдөрлөгийг 2017 оны 04 сарын 07-08 өдрүүдэд Тэнгэр худалдааны төвд зохион байгууллаа. Өдөрлөгт үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 150 аж ахуйн нэгж байгууллага бүтээгдэхүүнээ танилцуулан төрийн худалдан авалтанд санал болгох бүтээгдэхүүний жагсаалтыг хүргүүлэн төрийн өмчийн үйлдвэрийн газруудтай хамтран ажиллах талаар санал солилцсоны үр дүнд Нэхээсгүй эдлэл ХК нь Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллалаа. Өдөрлөгийн үеэр ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас санаачлан 500 аж ахуйн нэгж байгууллага, иргэний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний танилцуулга бүхий “Монголд үйлдвэрлэв-2017” үндэсний бүтээгдэхүүний каталогийг бэлтгэн хэвлүүлж төрийн өмчит үйлдвэрийн 85, орон нутгийн өмчит 78 байгууллага, салбарын яамд, УИХ-ын гишүүд,		70

		<p>агентлагуудын удирдлагууд болон худалдан авах үйл ажиллагаа хариуцсан газруудад хүргүүлээ. Каталогит орсон бүтээгдэхүүний танилцуулгыг худалдан авах ажиллагааны вэб сайтад байршууллаа.</p> <p>➤ 2015 оны тайланд төсвийн 30 байгууллагын 60,6 тэрбум төгрөгийн худалдан авалтаар дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн авсан ба худалдан авалтад давхардсан тоогоор 459 аж ахуйн нэгж байгууллага оролцсон бол 2016 онд төрийн болон төрийн өмчийн 63 байгууллага төсвийн хөрөнгөөр хийсэн худалдан авалтад давхардсан тоогоор 2608 аж ахуйн нэгж байгууллагаас 193,7 тэрбум төгрөгийн бараа, бүтээгдэхүүн нийлүүлсэн байна.</p> <p>Эдгээр худалдан авсан бүтээгдэхүүний 76% буюу 147,5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн, 24% нь ажил үйлчилгээ болон импортын бараа бүтээгдэхүүн /шатахуун, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж/ худалдан авсан байна.</p> <p>Дотоодын үйлдвэрээс хийсэн худалдан авалтыг өнгөрсөн оны мөн дүнтэй харьцуулбал 2.4 дахин өссөн байна.</p>		
	<p>XVII.2.2 Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 336 дугаар тогтоолоор баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах, уг жагсаалтад багтсан бараа, бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварыг нэмэгдүүлэх асуудлыг судлан санал боловсруулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгав.</p>	<p>-“Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах, уг жагсаалтад багтсан бараа, бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварыг нэмэгдүүлэх асуудлыг судлан санал боловсруулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгав.</p> <p>Жижиг, дунд үйлдвэр, эрхлэгчид, салбарын мэргэжлийн холбоодоос жагсаалтад нэмэх бараа бүтээгдэхүүний саналыг авч нэгтгэж байна.</p>		30
	<p>XVII.2.5 Нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдэд үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийг уриалж, худалдан авалт хийсэн байгууллагыг урамшуулах, худалдан авах</p>	<p>“ЗГ-ын 100 хоног” “Эрүүл хүнс- Эрүүл Монгол хүн, -Үндэсний үйлдвэрлэл” уриан дор 200 гаруй үндэсний үйлдвэрлэгчдийг оролцуулан үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгуулж, 1 тэрбум төгрөгний борлуулалт хийж, дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийг уриалж, төрийн худалдан авалтыг дэмжих үйл ажиллагаа, сурталчилгаа явуулсан.</p> <p>Ноос, ноолуур, хэвлэл, арьс шир-2016” үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг 2016-10-20-24 ны өдрүүдэд Мишээл экпо үзэсгэлэнгийн танхимд Арьс шир, ноос ноолуур,</p>		70

		<p>ажиллагааг дэмжсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.</p>	<p>хэвлэлийн холбоод хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд нийт 156 аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид 531 сая төгрөгийн борлуулалт хийж, загварын шоу зохион байгуулж, гутал, савхин хувцас, нэхий эдлэл, ноос, ноолууран бүтээгдэхүүнийг шилдэгийн шилдэг бүтээгдэхүүнээр, энэ салбарын үйлдвэрлэлт, борлуулалт, технологийн дэвшилээрээ тэргүүний үйлдвэрлэгчидийг шалгаруулав. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого, “Үндэсний үйлдвэрлэл”, Төрийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтуудын хүрээнд үндэсний үйлдвэрүүдийг дэмжих, хамтарч ажиллах нөхцлийг бүрдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх замаар эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг хамтдаа даван туулах, төрийн худалдан авалтад нийлүүлэх үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага – 2017” өдөрлөгийг 2017 оны 04 сарын 07-08 өдрүүдэд Тэнгэр худалдааны төвд зохион байгууллаа. Өдөрлөгт үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 150 аж ахуйн нэгж байгууллага бүтээгдэхүүнээ танилцуулан төрийн худалдан авалтанд санал болгох бүтээгдэхүүний жагсаалтыг хүргүүлэн төрийн өмчийн үйлдвэрийн газруудтай хамтран ажиллах талаар санал солилцсоны үр дүнд Нэхээсгүй эдлэл ХК нь Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Өдөрлөгийн үеэр ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас санаачлан 500 аж ахуйн нэгж байгууллага, иргэний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний танилцуулга бүхий “Монголд үйлдвэрлэв-2017” үндэсний бүтээгдэхүүний каталогийг бэлтгэн хэвлүүлж төрийн өмчит үйлдвэрийн 85, орон нутгийн өмчит 78 байгууллага, салбарын яамд, УИХ-ын гишүүд, агентлагуудын удирдлагууд болон худалдан авах үйл ажиллагаа хариуцсан газруудад хүргүүлээ.</p>		
		<p>XVII.2.6 Төсвийн байгууллагын байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.11-д заасны дагуу ерөнхий гэрээ байгуулан, мөн хуулийн 10,1 дүгээр зүйл, 53.5.7-д заасны дагуу тус тус зохион байгуулахыг Төрийн өмчийн</p>	<p>-ХХААХҮЯ-д 2017 онд төсвийн байгууллагын албан хэрэгцээнд ерөнхий гэрээ байгуулан худалдан авах жагсаалтаар бичгийн цаас 8,0 сая төгрөг, принтерийн хор 2.0 сая төгрөг, шатахууны зардал 7,0 сая төгрөгөөр худалдан авах захиалгыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2016 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 01/1469 тоот албан бичгээр хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>		100

		бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) болон бүх шатны төсвийн шууд захирагч нарт үүрэг болгов.			
16	2016 оны 10 дугаар сарын 05-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл	XIV.4.3 Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас олгосон зээл болох 3.0 их наяд төгрөгийн үнэ бүхий 371 төсөл, хөтөлбөрийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Хөгжлийн банктай хамтран нарийвчилсан шалгалт хийж, чанар, гүйцэтгэлийн талаарх дүнг 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Барилга, хот байгуулалтын сайл Г.Мөнхбаяр, Зам тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт тус тус даалгав.	Тус салбарт улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээл олгосон Дархан-Уул аймаг дахь “Үр тариа хадгалах 36.0 мянган тоннын багтаамжтай, төмөр бетон хийцтэй элеватор” худалдан авах үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт хийж, дүнг 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр яамны Дотоод аудитын хороогоор танилцуулж, 01 тоот тогтоол гаргуулж, дараахь арга хэмжээг авав. Үүнд: ЭЦГ-т мэдээллийг бичгээр гаргасны дагуу холбогдох шалгалтыг явуулж, албан тушаалын гэмт хэргийн шинжтэй гэх үндэслэлээр АТГ-т шилжүүлсэн. АТГ-аас эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд ТЭДС-ийн төлөөлөгч болон ХХААХҮЯ-ны төлөөллөөс гэрчээр мэдүүлэг авч эрүүгийн хэргийг шалгах ажиллагаа үргэлжилж байна; 2.Хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий этгээдүүдээс санад авч, бага үнийн саналаар Мөнх-Оргил трейд ХХК-аар үнэлгээг хийлгүүлсэн. Уг хөрөнгийг тендер шалгаруулалтаар 15,955.0 мянган төгрөгөөр нийлүүлэгдсэн байсан бол, 2016 оны 12 дугаар сарын 21-ний байдлаар гаргасан үнэлгээ нь 7,059.8 мянган төгрөгөөр үнэлгээг тогтоож, 8,935.2 мянган төгрөгөөр өмнө нь илүү үнэлсэн байна гэсэн дүгнэлт гарсан.		70
17	2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл	XIII.1.2 Хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудлыг судалж гаргасан дүгнэлтэд тусгагдсан асуудлыг шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хөрөнгө	Захиргааны хэм хэмжээний акт боловсруулах тухай бүрт иргэдээс болон салбарын байгууллага, мэргэшсэн төрийн бус байгууллагаас яамны цахим хуудсаар дамжуулан болон хэлэлцүүлэг зохион байгуулах замаар санал авч, төсөлд тусган ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төлөөлөл болох үе үеийн сайд, салбарын ахмадууд, эрдэмтэн судлаачид, ноос ноолуур, арьс шир, оёдол, газар тариалан эрхлэгчид, хүлэмжийн аж ахуй эрхлэгчид, мал аж ахуй, худалдаа эрхлэгчид, гурил үйлдвэрлэгчид, монголын тогооч нарын холбоо, мах боловсруулах үйлдвэрүүдийн төлөөллийг хүлээн авч уулзаж салбарт тулгамдаж буй асуудал,		70

		оруулагчид, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа хууль бус дарамт, шаардлагуудыг арилгаж, хүчингүй болгох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	хэрэгжиж буй ажлууд, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар харилцан санал солилцож, саналыг боловсруулагдаж буй хууль тогтоомжид тусгахаар ажиллаж байна.		
18	2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 55 дугаар тэмдэглэл	ХХҮ1.5.4 Малын гоц халдварт өвчинд тавих хяналтыг сайжруулах, өвөлжилт, хаваржилт хүндрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор байнгын бэлэн байдалд шилжиж, цаг хүндэрсэн нутаг дэвсгэрт өвөлжиж байгаа малчдад дэмжлэг, туслалцаа тогтмол үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт тус тус даалгав.	<p>ХХААХҮЯам өвөлжилтийн нөхцөл байдал, малын гоц халдварт өвчний мэдээ, мэдээллийг аймгуудаас авч, дүгнэлт хийж, шаардлагатай үед тулгамдсан асуудлыг Улсын онцгой комисс, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлж ажиллах зорилгоор яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 2016 оны 11 дүгээр сарын 15-наас 2017 оны 4 дүгээр сарын 1-нийг хүртэл хугацаанд ажиллах “Шуурхай штаб”-ыг байгуулан ажиллалаа.</p> <p>2016-2017 оны өвөл нутгийн 70 гаруй хувьд цастай байснаас 17 аймгийн 154 суманд 11-50 см зузаан цастай, нягт нь 0.11-0.45 г/см³ буюу хүндэрсэн нөхцөлд өвөлжлөө. 2016-2017 оны өвөлжилтийн нөхцөл байдалд Улсын онцгой комиссоос 2 удаагийн “Шуурхай бүлэг” ажиллуулж үнэлгээ хийсэн дүгнэлтийг үндэслэн хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын 5 удаагийн тогтоолоор 8.2 тэрбум төгрөгийн дараахь асуудлыг шийдвэрлэв. Үүнд:</p> <p>-12 аймагт 1.1 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр, сумдын эрүүл мэндийн төв, зарим аймгийн Онцгой байдал, ХХААГ-т нийт 44 автомашин, улсын нөөцийн 8920 тн өвсний үнийг 100 хувь, 7408 тн тэжээлийн үнийг 50 хувь чөлөөлж, 41.8 сая төгрөгийн малын эм бэлдмэл олгов.</p> <p>ХХААХҮЯ-наас онцгой байдлын албаны хүч хэрэгслийг нэмэгдүүлэн бэлтгэл бэлэн байдлын чадавхийг сайжруулах зорилгоор ОБЕГ-т 125-165 морины хүчин чадалтай 26 тракторыг шилжүүлсэн нь цас зайлуулах, түймрээс сэргийлэх зурвас гаргах, тариалангийн талбайд цас тогтоох зэрэг ажлын чадавхи нэмэгдсэн.</p> <p>Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ОУ-ын байгууллагуудтай хамтран ажиллаж 200-аас доош малтай, өрх толгойлсон эмэгтэй, олон хүүхэдтэй, өндөр настан, амьжиргааны 1 ба 2 дугаар зэрэглэлд байгаа зэрэг үзүүлэлтүүдээр 8459 өрхөд бэлэн мөнгө, хүнс, малын тэжээл, эм бэлдмэл, элгэвч, нэмнээ, хурганы уут зэрэг 4.1 тэрбум төгрөгийн тусламж хүргэгдээд байна.</p> <p>Мөн ХХААХҮ-ийн Сайдын санаачлагаар “Малчдад туслах сайн</p>		70

		<p>санааны аян"-ыг өрнүүлж, нийт 120 орчим төрийн болон төрийн бус байгууллага, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүд, элчин сайдын яам, их дээд сургуулиуд, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд, гадаадын улс оронд ажиллаж амьдарч буй иргэдийн холбоо, сүм хийд, иргэд нэгдэн 344,6 сая төгрөгийн мөнгөн болон эд материалын тусламжийг үзүүллээ. Энэхүү аяны хүрээнд Улсын онцгой комисс, тус яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран гаргасан цаг үеийн байдлын албан ёсны мэдээний дагуу цастай, зудын байдал хүндэрсэн мөн олон улсын байгууллагын тусламж хүрээгүй 9 аймгийн 30 сумдад 340 тонн хивэг, 90 тонн өвс, 300 багцын хамт /элгэвч, нэмнээ, ажлын болон эсгий гутал, дүнсэн тамхи, оймс, гутлын улавч, эсгий таавчиг, угаалгын нунтаг, саван, вазелин, боорцог, өмд цамцны хослол, ажлын болон хөвөнтэй бээлий, шүдэнз, лаа, цай, хөнжил гэх мэт/ хүргүүлэх ажлыг шуурхай зохион байгууллаа.</p> <p>МАН-н салбарын эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд малын хорогдол улсын хэмжээнд 515.6 мянга буюу оны эхний нийт 61.5 сая малын 0.8 хувийг эзэлж хэвийн өнгөрлөө.</p> <p>Энэ онд одоогийн байдлаар 21.0 сая төл хүлээн авч хамгийн олон төл хүлээн авсан он жил болж байна.</p>		
	<p>ХХҮҮ.6.1 Дарханы ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэн болон үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжтэй хамтран үрийн төрөлжсөн аж ахуйн байгуулах асуудлыг судалж танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт даалгав.</p>	<p>Үр тариа, тэжээлийн болон сэлгээний таримлын үрийн нөөц бүрдүүлэх, үр шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор “Үрийн тариалангийн талаар авах зарим арга хэмжээний тухай” ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 03.03-ний өдрийн А/ 31 дугаар тушаал гаргуулж хэрэгжилтийг зохион байгуулж байна. Энэхүү тушаалын дагуу тариалангийн үндсэн бүсүүдээс Үр тариа, улаанбуудай тэжээлийн таримлын үр үржүүлэх төрөлжсөн аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг хэсгийг ТНБД-ын А137 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулснаар Төв, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, аймгийн тариалан бүхий 10 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж үр үржүүлэх тусгай зөвшөөрөл олгон улмаар ТЭДС, Ургамал газар тариалангийн хүрээлэн, Үр үржүүлэгч аж ахуйн нэгжийг оролцуулан гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.Ингэснээр намрын ургацаас ТЭДС нь зөвхөн үр үржүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үржүүлсэн үрийг худалдан авч үрийн нөөц бүрдүүлэх боломж бүрдэж байна.</p>		100
	<p>ХХҮҮ.6.2 Хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор,</p>	<p>-Хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм болон бордоо, ургамал хамгааллын бодисыг гаалийн албан</p>		70

		комбайн, машин механизм болон бордоо, ургамал хамгааллын бодисыг гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийн үйлчлэх хугацааг сунгах асуудлыг судалж, холбогдох хуулийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгав.	татвараас чөлөөлөх хуулийн үйлчлэх хугацааг сунгах асуудлыг шийдвэрлүүлэхээр хуулийн төсөл, үзэл баримтлал батлуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Монгол Улсын Засгийн газрын 04 дүгээр сарын 12-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлээр гаалийн албан татвараас чөлөөлөх тухай болон гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын төслийг хэлэлцэн дэмжээд УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.		
19	2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 57 дугаар тэмдэглэл	ГҮ.1. Малын гоц халдварт хонины цэцэг өвчний өнөөгийн нөхцөл байдлын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хонины цэцэг өвчин аймаг, сум дамжин халдварлаж байгааг зогсоох зорилгоор уг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хуульд заасан журмын дагуу гэрээ шууд байгуулан худалдан авч, голомт бүхий бүс нутагт байгаа өвчлөмтгий мал сүргийг вакцинжуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд, вакцин худалдан авахад шаардагдах хөрөнгийг зохицуулан гаргаж санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгав.	Вакцин худалдах, худалдан авах гэрээг 2016.12.12-ны өдөр ОХУ-ын Бүх холбоотын мал, амьтны эрүүл мэндийн төвтэй байгуулсан. Гэрээнд зааснаар нийт 23.6 сая тун хонины цэцэг өвчний вакциныг 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2017.02.14-нийг хүртэлх хугацаанд 3 удаагийн татан авалтаар бүрэн хүлээж авсан. Өвчин гарсан аймаг, сумдад зохион байгуулах вакцинжуулалтын арга хэмжээг 2016 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс эхлүүлсэн бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 12 аймгийн 115 сумын 7.3 сая хонийг вакцинжуулалтанд хамруулаад байна. Вакцинжуулалтын үйлчилгээний хөлсөнд зориулж 1.1 тэрбум төгрөгийг Мал эмнэлэг, үржлийн газраас олгосон.		100
20	2016 оны 11	ХII.2.2 Үйлдвэржилтийн талаар	1. ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016-12-08-ны өдрийн А/ 157 дугаар		30

	<p>дүгээр сарын 30-ны өдөр</p> <p>58 дугаар тэмдэглэл</p>	<p>төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг яаралтай боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт даалгав.</p>	<p>тушаалаар “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр”-ийг боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр”-ийн төсөл, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулга, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалт, байгуулах үйлдвэрүүдийн товч танилцуулгыг боловсруулсан. Боловсруулах үйлдвэрийн байрлал, чиглэлийн талаарх сүүлийн жилүүдэд хийгдсэн, судалгаа, мэдээлэлд анализ хийх, хөтөлбөр боловсруулахтай холбогдуулан хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэжлийн холбоод/ Ноос, ноолуурын холбоо, Арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Хэвлэлийн мэргэжлийн холбоо, Монголын ойчид, модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо, Монголын барилга үйлдвэрлэлийн холбоо, Сав, баглаа боодлын холбоо, дахин боловсруулалтын холбоодтой уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрхэн цаашид хамтран ажиллах талаар хөтөлбөрт тусгах саналыг нь авч, харилцан санал бодлоо солилцсон.</p> <p>2.“Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн төсөл, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулга, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалт, байгуулах үйлдвэрүүдийн товч танилцуулгыг Засгийн газрын 2016-12-14-ний хуралдаанд хэлэлцүүлсэн. Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсний дагуу 60 дугаар тэмдэглэл гарсан.</p> <p>Уг тэмдэглэлийн дагуу Засгийн газрын гишүүдээс гарсан саналыг тусган, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p>		
21	<p>2016 оны 12 дугаар сарын 14-ний өдөр</p> <p>60 дугаар тэмдэглэл</p>	<p>XIV.2 Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журамд заасан “бүсэд газар эзэмших, ашиглах эрхийг төсөл сонгон шалгаруулах, эсхүл дуудлага худалдаа явуулах арга”-ыг хэрэглэлгүй газар олгосон асуудлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас шалгасан ажлын хэсгийн дүгнэлт, холбогдох хууль тогтоомжийг</p>	<p>-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоолын дагуу холбогдох арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулж, нотлох баримт цуглуулах, холбогдох албан тушаалтнуудаас тайлбар авах ажиллагаа хийгдсэн.</p> <p>-Албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлыг ХХААХҮЯ-аас Эрүүгийн цагдаагийн газарт хандаж шалгуулсан ба Эрүүгийн цагдаагийн газраас Авлигатай тэмцэх газарт тус яамны гаргасан гомдол шалгагдаж одоогоор Нийслэлийн Прокурор дээр хянагдаж байна.</p>		70

		<p>үндэслэн хууль зөрчсөн шийдвэр гаргасан болон хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, шаардлагатай бол хуулийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч, нийгэд мэдээлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгав.</p>			
		<p>ХХҮШ.7. “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөр боловсруулж байгаа ажлын явцын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан үйлдвэржилтийн зураглал гаргах, зах зээлийн судалгаа бүхий дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах боломжтой 100 үйлдвэрийг 21 аймагт байгуулах зэрэг хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан санал болон орон нутаг, яамдын саналыг тусган Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасан нөхцөл, шаардлагын дагуу “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгав.</p>	<p>Уг тэмдэглэлийн дагуу Засгийн газрын гишүүдээс гарсан саналыг “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн төсөлд тусган, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Үйлдвэржилт 21:100“ хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд:</p> <p>Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдалд үндэслэн макро, микро түвшингийн орчны үнэлгээ, шинжилгээ хийж, хөтөлбөрийн зорилго, зорилтыг томъёолж боловсруулсан.</p> <p>Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчид, мэргэжлийн судлаач эрдэмтэд, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй 11 удаа хэлэлцүүлэг хийж, саналуудыг боловсруулан хөтөлбөрийн төсөлд тусгасан.Хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл, тулгарч буй хүндрэлүүдийг тодорхойлж, хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж тодорхойлсон. Хөгжлийн бодлогын тухай хууль болон Хөгжлийн баримт бичиг боловсруулах журмын талаар ЗГХЭГ-ын референт, СЯ-ны мэргэжилтнүүдээс зөвлөгөө мэдээлэл авч, сургалтад яамны ажилтнуудыг оролцуулсан.</p> <p>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ТНБД-ын 2017-02-24-ний өдрийн А-57 тушаалаар шинэчлэн батлуулсан.</p> <p>Хөгжлийн бодлогын бичиг баримт боловсруулах тухай журмын дагуу хавсралтуудыг нэгтгэж Сайдын зөвлөлд танилцуулахад бэлтгэв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн эдийн засгийн тооцоолол хийх гэрээт ажилтнуудыг сонгон шалгаруулахаар зарлаад байна.</p>		30
22	2017 оны 01 дүгээр сарын	ҮШ. 3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан хуваарийн	Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр Засгийн газрын бодлого шийдвэрийг сурталчлах хуваарийн дагуу 5-р		100

	04-ний өдөр 1 дүгээр тэмдэглэл	дагуу Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны талаар болон өөрийн эрхлэх ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажлыг 14 хоног, сар, улирал бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тогтмол мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	дугаар сард Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, хөтөлбөр, хийж хэрэгжүүлж буй ажлын талаар 15 минутын нэвтрүүлэг хийв. Уг нэвтрүүлгийг 10 телевизээр болон ХХААХҮЯ-ны сайт, социал хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн болно.		
23	2017 оны 02 дугаар сарын 08-ны өдөр 6 дугаар тэмдэглэл	ХП.2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хийсэн ажлын айлчлалын дүнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хийсэн ажлын айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгав.	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган яамны газар хэлтсүүдэд хүргүүлэв. Төлөвлөгөөнд тусгагдсан заалт болох ОХУ-аас зургаадугаар сард багтаан шүлхий өвчнөөс сэргийлэх 4 сая гаруй тун вакцин нийлүүлэх тухай Хэлэлцээрт Талууд гарын үсэг зураад байна. Мөн ОХУ-аас газар тариалангийн тоног төхөөрөмж хөнгөлттэй нөхцөлөөр нийлүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байгаа болно.		30
24	2017 оны 3-р сарын 20-ны өдөр 13 дугаар тэмдэглэл	ҮП.2. 2017 оны 3 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулах Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын 16 дугаар хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн баримтлах удирдамжийг хэлэлцээд зөвшөөрөв. 2. Уг хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд бөгөөд тус комиссын Монголын хэсгийн	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын 16 дугаар хуралдаан Вьетнамын Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн сайдын ажлын ачааллаас шалтгаалан хойшлогдож, 8 дугаар сарын эхээр зохион байгуулахаар болсон. Монголын талын төлөөлөгчдийн удирдамжид тусгагдсан гол ажил бол Вьетнам Улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох ажлыг урагшлуулах чиглэлээр ажиллах, мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээг тохирох тухай юм. Хуралдааны үеэр байгуулах ёстой байсан “Мал эмнэлгийн хяналт, хорио цээрийн салбарт хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилын Вьетнам Улсад хийсэн албан айлчлалын үеэр байгуулсан болно.		0

		<p>дарга П.Сэргэлэнд даалгав.</p> <p>ХҮҮ.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов. 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов: 2.1. үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт бүрэн тусгаж хүрэх түвшинг бодитой тогтоох; 2.2. жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг оны эхнээс жигд хангаж ажиллах.</p>	<p>2018 оны төсвийн төлөвлөгөөг боловсруулах үед Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын туссан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллах болно.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p>		70
25	2017 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл	<p>ҮҮ.2. Уг хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, тус комиссын Монголын хэсгийн дарга П.Сэргэлэнд даалгав.</p>	<p>Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын 16 дугаар хуралдаанд оролцох Монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд бүх яамдаас албан тушаалтны нэр дэвшүүлсэн санал авсан болно.</p>		0
26	2017 оны 5 дугаар сарын 2-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл	<p>П. Улаанбаатар хотод 2017 оны 4 дүгээр сарын 5-6-ны өдрүүдэд зохион байгуулсан Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны монгол, Италийн засгийн газар хоорондын холимог комиссын хоёрдугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний</p>	<p>Монгол - Италийн Засгийн газар хоорондын холимог комиссын хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулж бүх яамд, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Үндэсний хөгжлийн газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимд тус тус хүргүүлэв.</p>		30

		төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг ХХААХҮ-ийн сайд, тус комиссын Монголын хэсгийн дарга П.Сэргэлэнд даалгав.		
--	--	--	--	--

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР